MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,100.397... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.08.19. Баасан. №145 (4515) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

ШАР МЭДЭЭ

С.БАЯР Н.ДЭМБЭРЭЛИЙГ АЛНА ХЭМЭЭН ЗАНАЛХИЙЛЖЭЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

ЭРДОГАН 38 МЯНГАН ХОРИГДЛОО “ӨРШӨӨВ”

IV нүүрт

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



Дугаарын 60 мөр

## Тамирчдыг шүүмжлэх эрх хэнд ч байх ёсгүй

Н.ПУНЦАГБОЛД

Хүн төрөлхтний эв нэгдлийн их баяр цэнгэл болох зуны олимпийн 31 дүгээр наадам Бразилын Рио хотноо үргэлжилж байна. Манай улс энэ удаагийн Олимпийн наадамд 43 тамирчны илгээсэн нь түүхэн амжилт болоод байгаа юм. Гэхдээ олон тамирчны бүрэлдэхүүнтэй оролцсон ч одоогийн байдлаар манайхны авсан медаль Бээжин, Лондонгийн олимпоос авсны тоонд арай л хүрээгүй байна. Гэхдээ найдлага дуусаагүй байгаа. Бид одоо чөлөөтийн тамирчдынхаа дээлийн захыг мушгина. Хэдийгээр Олимпийн наадам дуусах болоогүй байгаа ч иргэд тамирчдаа муу муухайгаар нь дуудаж, улс төртэй хутгаж, элдвээр муулах байдал багагүй газар авч байна. Тэр дундаа жүдогийнхныг тултал хэмлэсэн. Боксын тамирчдыг ч гэсэн “хөдөлж чадахгүй, үлбэгэр, сулбагар” энэ тэрээс авахуулаад хэчнээн муулж байгаа билээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ЫН ЗАСГИЙН ГАЗАР

# ЖООМОО БИШ ГЭРЭЭ ШАТААЧИХЛАА

Б.ТОГТОХ

МАН-ын байгуулсан “мэргэжлийн” гэх тодотгол зүүсэн Засгийн газар байгуулагдсанаас хойшхи нэг сарын хугацаанд олон ч дуулиан дагуулсан мэдэгдэл хийж, тэр хэрээр олны анхаарлыг татах шийдвэр гаргаж байна. Өөрөөр хэлбэл, олны анхаарал татаж л байвал болно гэсэн сэтгэхүйгээр тэд хандаж улсынхаа нэрийг ч үл тоомсорлож дотоод асуудлаа дэлгэж орхилоо. Монгол Улсын төсөв улайж, валютын нөөц хомсдож цалингаа ч тавьж чадахгүйд хүрсэн тухай Сангийн сайдынх нь мэдэгдэл Монгол Улсын нэрээр олон улсын хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцааны ханшид нөлөөлж, нөгөө талаар манай улсын нэр хүнд ч унаж эхэлсэн. Валютын нөөц хомс байгаа тухай Төв банкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы мэдэгдлийн дараа олон улсын хөрөнгийн биржид арилжаалагдаж буй Чингис бондын өгөөж 5.42 хувиас 5.71 болж 5.4 хувиар муудсан бол Сангийн сайдын мэдэгдлийн дараа мөн л огцом муудсан тухай мэдээлэл олон улсын санхүүгийн хэвлэл мэдээллээр гарч эхэлсэн юм. Жоомоо шатаах гээд гэрээ шатаахын үлгэрээр өмнөх намынхаа нэр хүндийг унагаж, өөрсдөө цэвэрхэн мултрахын төлөө хийсэн энэ үйлдэл нь улс орны хувь заяанд тийм ч өөдрөгөөр нөлөөлж чадсангүй.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +21
Шөнө +11

# О.ОТГОНБАЯР: “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”-ИЙН ТӨРӨЛЖСӨН АРХИВ “А” ҮНЭЛГЭЭ АВСАН

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс







| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2250.00 | 2273.00 | ФУНТ | 2884.00 | 3009.00 |
| ЕВРО | 2514.00 | 2605.00 | РУБЛЬ | 33.10 | 37.50 |
| ИЕН | 22.26 | 23.11 | ЮАНЬ | 338.00 | 345.90 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2252.00 | 2273.00 | ФУНТ | 2913.00 | 3037.00 |
| ЕВРО | 2521.00 | 2630.00 | РУБЛЬ | 34.14 | 37.72 |
| ИЕН | 22.27 | 23.33 | ЮАНЬ | 339.30 | 346.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Монгол санхүүгийн байдлаа зарласан нь зоригтой алхам гэв

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбаттай ОУВС-гийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Нил Сакер, Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч Коши Матай тэргүүтэй төлөөлөгчид уулзлаа. Уулзалтын эхэнд Ерөнхий сайд, Монгол Улс урт хугацаанд ОУВС-тай хамтран ажиллаж ирсэн, энэ уламжлал цаашид ч үргэлжилнэ гэдэгт итгэж буйгаа илэрхийлэв. Харин ноён Коши Матай “Монгол Улсад өнөөдөр нэгэнт бий болсон эдийн засгийн хямралыг давахын тулд төсөв, санхүүгийн бодит байдлаа ил тод ард түмэндээ мэдээлж, олон жилийн турш тусдаа явсан төсвүүдийг нэгтгэж нэг төсөвтэй болгож байгаа нь маш зөв эхлэл. Одоо эдгээр зоригтой алхмаа зөв шийдлээр үргэлжлүүлэх хэрэгтэй. Бидний хувьд энэ удаа Монгол Улсын шинэ Засгийн газар эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, гарц шийдлээ юу гэж харж байгаатай танилцах зорилготой богино хугацаагаар ирлээ. Хэрвээ цаашид ОУВС-тай хамтарч ажиллахаар бол манайхаас өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нэлээд хэдэн хоногийн хугацаатай ирэх юм. ОУВС-гийн хувьд Монгол Улсын төлбөрийн тэнцэл, ам.долларын орж гарах урсгал, ер нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайн мэдэж байсан гэлээ. Түүнчлэн нөхцөл байдал ийм хүнд байхад арилжааны банкууд доллар худалдахаа хязгаарлаж, иргэдийн гар дээр их хэмжээний бэлэн мөнгө төвлөрч байгаа нь долларын ханшийг улам өсгөх шалтгаан болж байгааг ОУВС-гийнхан онцоллоо.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

**Ерөнхий эрхлэгч:** С.ГАНТОГОО

**Орлогч эрхлэгч** Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

**Хариуцлагатай нарийн бичгийн дарга:** Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

**Ахлах редактор:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба** Н.ПУНЦАГБОЛД 88096454

**Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:** Б.ӨНӨРТОГТОХ 88006842

**Гэрэл зургийн алба:** Г.АРГУУЖИН 96017873

**Компьютерийн алба:** Б.ГАНЗОРИГ 99998796

**Маркетинг, зар сурталчилгааны алба:** Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

**Захиалга, борлуулалтын алба:** М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

**Дугаарыг эрхэлсэн** Э.ЭНХЦЭЦЭГ

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

SPEAK OUT

# “АН ЦААШДАА БОДЛОГЫН НАМ БОЛЖ ӨӨРЧЛӨГДӨНӨ”

Ж.ОТГОН

*Ардчилсан намын шинэчлэлийн ажлын хэсгээс “Улс төрийн намын шинэчлэл, шийдэл” сэдвээр эрдэмтэн, судлаачидтай хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт эрдэмтэн, судлаачид илтгэл тавьж, улс төрийн намын шинэчлэлийн асуудлаар нийгэмд тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдэх шийдлүүд, улс төрийн намын тухай хуулийн төсөл, нээлттэй ил тод байдал, гишүүнчлэл гэх мэт өргөн хүрээний сэдвүүдээр хэлэлцлээ. Энэхүү хэлэлцүүлгийн үеэр зарим гишүүдийн сэтгэгдлийг сонслоо.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Б.Ган–Очир: Өөрчлөлт, шинэчлэлийн тэргүүн магнайд АН явах ёстой



*/АН-ын шинэчлэлийн ажлын хэсгийн зохицуулагч/*

-Сонгуульд улс төрийн намууд бүгдээрээ оролцсон. Улмаар АН ялагдсан. Энэ нь сонгуулийн үр дүнгээр гарсан бодит факт юм. Үүний үр дүнд улс төрийн намууд шинэчлэгдэх, өөрчлөгдөх ёстой. Харин энэхүү өөрчлөлт, шинэчлэлийн тэргүүн магнайд АН явах ёстой гэдэг өнцгөөс нэлээд олон ажлын хэсэг, хөдөлгөөнүүд нэгдсэн зохион байгуулалтад орж, төв намын дэргэд ажлын хэсэг гарсан. Энэхүү ажлын хэсэгт Шинэчлэлийн хөдөлгөөн, Нэгдсэн хөдөлгөөн, манай улс төрийн намын залуус, сонгуульд нэр дэвшсэн хүмүүс гээд нэлээд олон Хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарлаа. Ажлын хэсэг энэ сарын 25-нд болох ҮЗХ-ны хурлаас өмнө нэлээд хэдэн шат дараатай үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Түүнчлэн арванхоёрдугаар сард болох намын их хуралд бэлтгэж, олон төрлийн дүрмийн өөрчлөлт хийх болно. Бүх зүйл эхлэхийн өмнө хуучин буюу өнгөрсөн цаг хугацаандаа онош тавих, одоо байгаа зүйлээ дүгнэх, ирээдүйн гарц шийдлээ гаргах хамгийн эхний алхмыг эрдэмтэн, судлаачидтай хамтарсан хэлэлцүүлгээр эхлүүлж байна. Энэхүү хэлэлцүүлгийн гол зорилго нь “Монголын улс төрийн намуудыг шинэчлэл шийдэл” гэдэг агуулга дотор өрнүүлж байна. Нийтдээ зургаан судлаач оролцож байгаа. Ер нь улс төрийн намуудад иргэдийн итгэх итгэлийн хувьд Монгол Улсын хэмжээнд хүн амын бараг 80 орчим хувь нь “итгэхгүй” байна гэсэн дундаж хэмжээний судалгаанууд байдаг. Гэхдээ энэ нь улс төрийн намууд дампуураад, муудчихсан гэсэн үг биш. Маш цөөхөн тохиолдолд намдаа итгэх иргэдийн итгэл өндөр хувьтай байдаг. Тухайлбал, намдаа итгэх итгэл хойд Солонгост хамгийн өндөр, БНХАУ-д 80 гаруй хувьтай байдаг. Ер нь ардчилсан тогтолцоо өсөхийн хэрээр намуудад итгэх итгэл болон эрх баригчдад шүүмжлэлтэй ханддаг байдал нь улам өсдөг. Гэхдээ зүгээр ийм байна гээд орхих биш. Улс орны хөгжлийг, Монголын төрийг бүрэлдүүлж байгаа намууд 100 хувь зөв залж, удирдаж байгаа юу гэвэл нийт залуус, судлаачид “үгүй” гэдэг хариулт өгч байгаа. Үгүй гэдэг хариултыг өгчихөөд “Тэгвэл намууд өөрчлөгдөх ёстой юу” гэхээр “тийм” гэхээс өөр хариултгүй байж болохгүй. Тиймээс хамгийн эхлээд онол, үзэл баримтлал, боловсон хүчиний хувьд хийх шийдлүүдээрээ ялгарах ёстой гэдэг дээр гарц гаргах учиртай. Тиймээс ч шинэчлэлийн ажлыг судлаачид, болоод эрдэмтдээс эхлэх нь хамгийн зөв буюу хамгийн гол цэгээсээ эхэлж байгаа хэрэг гэж үзэж байгаа.

### Ц.Батболд: Засгийн газарт фракцийг байлгаж болохгүй



*/МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш/*

-Би энэхүү хэлэлцүүлэгт “Монголын улс төрийн намын шинэчлэл” сэдвээр илтгэл тавих гэж байна. Гол асуудал нь Монголын улс төрийн намуудад ард түмэн нэлээд шүүмжлэлтэй хандаж байгаа. Эдгээр намууд тодорхой хэмжээнд шинэчлэгдэх шаардлага ч гарсан. Тиймээс яаж, ямар шугамаар шинэчлэгдэх эсэх, ямар үзэл бодол баримтлах, хүний нөөц боловсон хүчний асуудал дээр хэрхэн хандах, санхүүжилтын асуудал гээд олон зүйл байна. Ер нь намууд шинэчлэл хийхдээ хамгийн түрүүнд намын дүрмээсээ эхэлнэ. Өөрөөр хэлбэл, дүрмээ гадаад эрх зүйн орчинтой болон ирээдүйн эрх зүйн сайжруулах орчинтой уялдуулсан дүрэм боловсруулах хэрэгтэй. Түүнчлэн дотоод фракцийн асуудлуудаа намаасаа гаргахгүйгээр хязгаарласан дүрэм боловсруулж эхлэх учиртай. Түүнээс фракци нам дотор байх ёстой үзэгдэл. Харин төрийн албаны ялангуяа Засгийн газарт байлгаж болохгүй. Улс төрийн намууд дүрмээрээ л явдаг байх шаардлагатай байгаа юм. Хэрвээ дүрмээ баримтлахгүй бол хариуцлага тооцдог тогтолцоотой байж чадвал сая намууд зөв хөдөлж эхлэх учиртай. Нөгөө талаар төрийн санхүүжилттэй болбол намууд бизнесийн хамаарлаас гарна. Төрийн санхүүжилтыг дагаад, намын нийгэм, улс төрийн хариуцлага нэмэгдэж, төрөөс, иргэний нийгмийн зүгээс намын дотоод хяналтын байгууллагуудын зүгээс нээлттэйгээр хяналт тавиад эхлэхээр нам цэвэршиж эхэлнэ гэсэн үг.

### П.Галиндэв: Ойрын хугацаанд АН–ын шинэчлэл бодит ажил болно



*/АН-ын шинэчлэлийн ажлын хэсгийн дарга/*

-АН-ын шинэчлэлийн асуудал нэлээд олон жил яригдсан зүйл. Улс төрийн намын гол үүрэг нь улс орноо хөгжлийн бодлогоор манлайлж, хөгжүүлэх учиртай. Тиймээс намууд өөрсдөө тогтвортой бодлоготой байх ёстой. Ер нь зөвхөн АН гэлтгүй Монголын бүх Улс төрийн намуудад хөгжлийн үйл явц, тогтвортой хөгжлийн бодлоготой байх асуудал үгүйлэгдэж байгаа. Тиймээс улс төрийн намын хөгжил, шинэчлэлийн асуудалд АН түүчээлж, шинэчлэлийн асуудлыг авч хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, АН-ын даргад шинэчлэх ажлын хэсэг гарсан. Энэхүү ажлын хэсэг өнөөдөр шинэчлэлийн ажлаа ийнхүү эхлүүлж байна. АН цаашдаа бодлогын нам болж өөрчлөгдөнө. Энэ дагуу улс орондоо тогтвортой хөгжлийн бодлогоо хангаж чадахуйц үлгэр дууриаллыг намуудад авч ирэхээр шинэчлэлийн ажил хийгдээд эхэлчихсэн байгаа. Цаашид намыг жирийн гишүүд, дэмжигчидтэйгээ уулзаж, шинэчлэлийн асуудлаар санал бодлыг нь сонсох болно. Түүнчлэн нийгмийн хүрээнд тодорхой судалгаануудыг хийх төлөвлөгөөтэй байгаа. Ойрын хугацаанд АН-ын шинэчлэл бодит ажил болж хэрэгжих болно.

### С.Эрдэнэболд: АН зайлшгүй шинэчлэгдэх шаардлага тулгараад байна



*/АН-ын шинэчлэлийн ажлын хэсгийн гишүүн/*

-Монгол Улс ардчиллын замаар 26 дахь жилээ замнаж байгаа. АН бол сүүлийн 26 жилийн хугацаанд Монголын шийдвэр гаргах бодлого боловсруулах төвшинд ойрхон буюу тулгуур болон ажилласан. Одоо харин зайлшгүй шинэчлэгдэх шаардлага тулгараад байна. Хамгийн том сургамж нь сая болсон сонгуулийн үр дүн байлаа. Тиймээс бид намын шинэчлэлийг маш өргөн хүрээнд олон жилийн хугацаанд харж байгаа. Зүгээр нэг намын даргыг солих зэрэг жижиг өөрчлөлт хийснээр нам шинэчлэгдэхгүй. Харин үзэл санаа, дүрэм, хариуцлага, хүний нөөц, санхүүжилтын хувьд маш сайн нам болж төлөвших ёстой. Ирэх дөрвөн жил АН-д энэ боломжийг олгож байгаа. Манай намын шинэчлэлийг дэмжиж байгаа мянга мянган хүмүүс байна. Тэдгээр хүмүүсээс төлөөлөөд явж байгаа залуусын, ахмадын, эмэгтэйчүүдийн гээд олон хөдөлгөөнүүд байгаа. Одоогоор нэр нь гараад эвлэлдэн нэгдээд явж байгаа нь цөөхөн байгаа ч цаана нь яг ижил бодолтой олон хүмүүс бий. Тиймээс ч намын шинэчлэлийн ажлыг хүртээмжтэй олон хүний оролцоотой шилэн ил тод байлгахаар зорьж байгаа. Үүний хамгийн эхний ажил нь өнөөдрийн эрдэмтэн судлаачидтай хамтран зохион байгуулж байгаа энэхүү хэлэлцүүлэг юм. Үүн шиг хурлыг цаашдаа маш олон удаа зохион байгуулах болно.

### Э.Бямбацэрэн: Маш сайн үндсэн дүрэмтэй болчихвол бүх асуудал шийдэгдэнэ



*/АН-ын шинэчлэлийн ажлын хэсгийн гишүүн/*

-Үндсэн хууль бол тухайн улс орны бүхий л асуудлыг зохицуулж байдаг. Үүнтэй адил АН-ын Үндсэн дүрэм бол намын бүхий л дотоод асуудлыг зохицуулах хууль дүрэм байх учиртай. Тэгэхээр Үндсэн дүрмээ л олуулаа хэлэлцэж байгаад, сайн буюу хамгийн дотоод ардчилалтай дүрмийг боловсруулах шаардлагатай. Тиймээс энэ ажилд эрдэмтэн судлаач, залуус, ахмад үе гээд бүхий л шатны санааг оролцуулах хэрэгтэй. Хэрвээ маш сайн Үндсэн дүрэмтэй болчихвол бүх асуудал нэг талдаа шийдэгдэх болно. Миний бодлоор бидний хамгийн эхний асуудал намын дарга гэхээсээ илүү Үндсэн дүрмээ л сайжруулах хэрэгтэй байна. Гэхдээ дараагийн намын дарга шинэчлэлийг дэмждэг хүн байх нь зөв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ерөнхий сайдад мэдэгдэл хүргүүлэв

МҮЭ-ийн холбоноосЕрөнхий сайд Ж.Эрдэнэбатад санал хүргүүлсэн билээ. Тодруулбал, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2015-2016 оны Улсын хэлэлцээр, Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд хүргүүлсэн “Хөдөлмөрчдийн нийгмийн захиалга” баримт бичиг болон УИХ-ын 2016 оны сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан МАН-ын мөрийн хөтөлбөрийг үндэслэн яаралтай шийдвэрлэхүйц тулгамдсан асуудлаар санал хүргүүлсэн юм. Гэвч уг саналыг хэрхэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх талаар албан ёсны хариу ирүүлээгүй байгаа аж. Тиймээс өчигдөр МҮЭ-ийн холбоо Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад хандан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороог яаралтай хуралдуулан, асуудлыг бодитойгоор хэлэлцэж шийдвэрлэхийг санал болгож, мэдэгдэл хүргүүллээ.

## Агентлагийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгчид томилогдлоо

Засгийн газрын ээлжит хуралдаанаар ЗГХЭГ-ын дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр У.Бямбасүрэн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Б.Чинбат томилов. Түүнчдэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр О.Алтансүх, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Д.Мөрөнг томилжээ. Мөн шүүхийн шийдвэрийн дагуу С.Энхтүвшинг Цаг уур, орчны шинжилгээний газрын ажилд буцаан томиллоо.

ШАР МЭДЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## С.Баяр Н.Дэмбэрэлийг ална хэмээн заналхийлжээ

Н.БОЛД

УИХ-ын ээлжит сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулсан МАН-ынхан дотроо хагарч эхэлсэн нь эхнээсээ олонд ил боллоо. Намын дарга М.Энхболдод дургүйцсэн гишүүд их байгаа тухай яриа газар авч эхэлсэн энэ үед сонгуулиар МАН-ын сурталчилгааг хариуцсан хоёр эрхэм цахим ертөнцөөр дайтаж эхэллээ. Тодруулбал, МАН-ын дарга Ерөнхий сайд асан С.Баяр намынхаа залуу лидер гэгдэх Н.Дэмбэрэлийг утсаар сүрдүүлж, алах талахдаа тулсан бололтой. Н.Дэмбэрэл өөрийн твиттер хуудсаараа дамжуулж, “Хүүе. С.Баяр яриад, миний яриаг бичиж байгаа, ална гэнэ ээ. С.Баяр гэдэг хүн дарамтална гэнэ ээ. Улсаа зарсан новш зайлуул таарна. АНУ-д долоон байртай бил үү” хэмээн бичиж. Мөн “Оффшор Баяр тамирчдад мөнгө өгөх үү. Хоншоор нь дутна даа. С.Баяр гэдэг хүн улсаа зараад хаа хүрэв. Баяр намайг тоохоор овоо болж дээ. Албан тушаал биш ээ. Авгай хүүхдээсээ сал Баяр аа. Ха ха, Хэн миний постыг үзэж байна гэсэн Баяр л гэнэ. Ккк. Ичиж үхээч Баяр гуай” гэх зэргээр цахим хуудсаар түүн рүү дайрсан байна. Мөн твиттерээр “С.Баяр хэрхэн юу ярьсан тухай ярилцлага авах мэдээллийн суваг байвал өгнө” гэж ч жиргэсэн байв. М.Энхболдын хүн гэгдэх Н.Дэмбэрэл яагаад ийн С.Баяртай цахимаар дайтах болсон нь олон хүний анхаарлыг татаад байна. Зарим хүмүүс томоохон асуудал үүссэн хэмээн хардаж байгаа юм. Ямар ч байсан МАН-ынхан хоорондоо алалцаж, булхайгаа дэлгэж эхэллээ.

## ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

# Тамирчдыг шүүмжлэх эрх хэнд ч байх ёсгүй

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Нэг талаар цахим ертөнц хөгжиж, хүн бүр дураараа чалчих эрхтэй байгаагийн хар гай. Гэхдээ амнаас гарч байгаа авиа, бичиж байгаа зүйлээс мэддэг байх хэрэгтэй шүү дээ. Бээжингийн олимпийн наадмаас манай тамирчид хоёр алт, хоёр мөнгөн медаль хүртсэн. Түүхэн амжилт байсан нь үнэн. Лондонгоос бүр таван медаль авсан. Жүдочид хоёрыг, боксынхон бас хоёр медаль авсан. Тэгээд чөлөөтөөс С.Батцэцэг нүүр тахалсан. Энэ удаад жүдо, бокс тус бүр нэг медаль авлаа. Одоо чөлөөтийнхөн хэдэн ч медаль авч магадгүй шүү дээ. Юм дуусаагүй байна. Манай тамирчид өмнөх амжилтаа давтаж, илүү гарч ч магадгүй. Гэхдээ хамгийн гол нь тамирчид маань медаль авч чадсан ч бай, чадаагүй ч бай муу хэлэх эрх хэнд ч байх ёсгүй. Бид ер нь хэзээ Олимпийн медаль, байр голдог болчихсон юм. Тэгж ярьвал Олимпийн наадамд оролцоно гэдэг өөрөө том амжилт шүү. Жүдочид анх удаа бараг л бүтэн багаараа оролцлоо. Энэ амжилт биш үү. Хуучин ганц хүнд найддаг, тэр нь мултарвал тэгсхийгээд өнгөрдөг байсан. Гэтэл одоо жин болгонд барилдаж байгаа бөхөөсөө медаль хүлээдэг болсон. Энэ амжилт биш гэж үү. Мэдээж медаль авбал сайхан. Боксчид гэхэд энэ удаад зургуулаа очлоо. Нэг хүн хүрэл авлаа. Шүүлт жаахан аятайхан байсан бол 2-3 медаль зулгаах боломж байж л байсан. Гэхдээ л болж өгсөнгүй. Тийм болохоор бүгд ялагдахад нь сэтгэлийн дэм хайрлаад, ялахад нь нийтээрээ бахархаад л явах ёстой. "Тамирчны ялалт хямдхан олдоогүй" гэж нэг сайхан дуу байгаа даа. Тамирчны ялалт үнэхээр их үнэ цэнээр олддог юм. Олимпийн наадамд оролцохын төлөө дөрвөн жил хэчнээн литр хөлс урсгаж, цадталаа идэж ч чадахгүй зүтгэж байгаа тэдний хөдөлмөрийг өөрсдөөс нь өөр хэн ойлгох юм бэ. Бөмбөрцгийн томчуудтай барилдаж, тулалдах нь битгий хэл их спортоор ганц ч өдөр хичээллэж, хүний тэсч чадах хязгаарт тулж үзээгүй нөхдүүд бол дуугаа татаад л сууж байсан нь дээр. Ухаалаг утас ухаад, ухаангүй үгс бичээд сууж байхаасаа ичих хэрэгтэй. Олимпийн наадамд очоод эхний тойрогтоо ялагдсан байсан ч тэр тамирчинг шүүмжлэх, элдвээр хэлэх хэрэггүй. Тэртэй тэргүй ялагдах гэж очоогүй. Ялагдвал нулимсаа барж, дотроосоо нурж байгаа хүмүүс. Д.Отгондалай гэхэд ард түмнийхээ итгэлийг алдлаа гээд л уйлж байсан. Ялагдлын зовлонг тэднээс өөр хэн илүү мэдрэх юм бэ. Тийм байхад нь харин ч сэтгэлээр өргөөд, дэмжээд, улам их эрч хүчтэйгээр эргэж ирэхэд нь туслах хэрэгтэй биз дээ. Спорт гэдэг ялалт, ялагдал ээлжилдэг хорвоо. Цуут аваргууд ч уйлж суудаг өдөр байдаг л юм. Хэний ч таамаглаагүй тамирчин аваргуудыг ялж түрүүлж л байдаг. Нэг удаа ялагдлаа гээд тэмцээн дуусчихгүй. Элдвээр хэлсэн хэлээгүй тамирчид маань алдаан дээрээсээ суралцаад, илүү сайжрахын төлөө л тэмцэнэ. Түүнээс биш нэг ялагдлаа гээд буугаад өгчихдөггүй юм. Жаахан ухаантай байцгаая та минь ээ.




# МАН-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖООМОО БИШ ГЭРЭЭ ШАТААЧИХЛАА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Олон улсын валютын сан түүний энэ мэдэгдлийг сайшаасан ч эцсийн дүндээ энэ улсын хувь заяа тэдэнд сонин биш. Валютын зээл авах "Стэнд бай" хөтөлбөрт хамрагдахыг байсхийгээд л сануулж ирсэн тэдэнд бид жоомоо шатаана уу, гэрээ шатаана уу гэдэг огт хамаагүй гэхэд хэтийдэхгүй. Энэ бүхний дараа Засгийн газар юу хийх бол гэдэг нь мэдээж олон ч хүний хүлээх сэдэв болж, эдийн засагчдын ч анхаарлыг зүй ёсоор татсан. Үнэхээр л төсөв улайж, улсын данс хоосорч цалингаа ч тавьж чадахгүйд хүрсэн бол Ж.Эрдэнэбатын Засгийн газар эндээс яаж гарах нь тун ч сонирхолтой байв. Тэгвэл энэ Засгийн газрын гарц нь мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлж, олон мянган аж ахуйн нэгжийн хаалгыг бариулж, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн зээл авах эх үүсвэрийг хаах шийдвэр байжээ. Тодруулбал, Монголбанкны дэргэдэх Захирлуудын зөвлөл өчигдөр ээлжит хуралдаанаа хийж 10.5 хувьтай байсан бодлогын хүүг 4.5-аар нэмэгдүүлж 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргажээ. Хэдийгээр инфляцийг бага төвшинд хадгалж ирсэн ч ам.долларын төгрөгтэй харьцах ханш 7.9 хувиар суларсан учраас эдийн засгийн орчноо бэхжүүлэх, мөнгөний үнэ ханшийг нэмэгдүүлж, дэлхийд хамгийн сул мөнгөн тэмдэгтээр нэрлэгдээд байгаа монгол төгрөгийн ханшийг хамгаалах үүднээс энэхүү шийдвэрийг гаргахад хүрчээ. Нэг талаас харвал энэ тун зөв шийдвэр байж мэдэх. Гэвч нөгөө талаас харвал зүүний чиглэлтэй, халамжийг зорилгоо болгодог МАН-ын тэргүүлсэн Засгийн газар хэтэрхий харгис шийдвэр гаргалаа гэж хэлж болно. Мөнгөний бодлогын хүү гэдэг нь төв банк арилжааны банкуудаас татан төвлөрүүлж байгаа хөрөнгөндөө жилд төлөх хүүгийн хэмжээг хэлдэг. Бодлогын хүү өндөр байснаар арилжааны банкуудын гадагшаа зээл гаргах сонирхол буурч, зээлийн хүүгийн хэмжээ нэмэгддэг. Ингэснээр олон мянган аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкууд үүд хаалгаа хааж, тэр хэрээр зах зээлээс аж ахуйн нэгжүүд арчигдахад хүрнэ. Сөрөг хүчин байсан өнгөрсөн дөрвөн жилд МАН-ынхан бодлогын хүү 13.5 хувь байгаа нь буруу, маш олон аж ахуйн нэгж дампуурлаа зарлалаа хэмээн эсэргүүцэж, олон ч гишүүд аж ахуйн нэгжүүдийн хувь тавилангийн төлөө санаа чилээж байгаагаа илэрхийлж байлаа. Л.Энх-Амгалан, Ч.Хүрэлбаатар, өдгөө Сангийн сайдаар ажиллаж буй Б.Чойжилсүрэн нарын олон ч гишүүдийн амнаас аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж дампуурлаа, зээлийн хүүгээ бууруул, мөнгөний бодлогын хүү хэтэрхий чанга байна гэх үг гарч байсан нь хэвлэлийн хуудаснаа дурайж буй. Гэтэл тэд эрх барьж эхлээд л өмөөрч байсан хэсэг бүлгийнхээ өр лүү өшиглөх шийдвэр гаргаж орхив. Хамгийн хачирхалтай нь Ж.Эрдэнэбат Ерөнхий сайдаар томилогдсон даруйдаа арилжааны банкуудад зээлийн хүүгээ бууруулах чиглэл өгч байлаа. Гэтэл өчигдөр гарсан энэ шийдвэрээр хүү буурах бус харин ч улам илүү нэмэгдэх нь тодорхой болж байна. Амьтай голтой төдий гэлдэрч буй ипотекийн найман хувийн зээл ч үндсэндээ зогсонги байдалд орно гэсэн үг. Арилжааны банкууд хэзээд эрсдэлтэй алхам хийхгүй. Тиймдээ ч Төвбанкны гаргасан шийдвэрийг сөрж, Ерөнхий сайдын шийдвэрийн төлөө зээлийн хүүгээ бууруулж, эрсдэлтэй нөхцөлд зээл их хэмжээгээр гаргахгүй билээ. Тиймдээ ч төгрөгийн үнэ цэнээ хадгалах гэсэн Төвбанкны шийдвэр жоомыг биш гэрээ шатаах шийдвэр болон хувирчихлаа. Үүнийг ч мэргэжлийн эдийн засагчид дуу нэгтэй ярьж эхэлжээ. Өнгөрсөн нэг сарын хугацаанд Ж.Эрдэнэбат Ерөнхий сайдын ам ажил нь алд дэлэм зөрөөд байгаа нь хачирхалтай. Гаргасан шийдвэр бүхэн нь ч нөгөөтэйгөө зөрчилдөж байгаа учраас ар араасаа хийсэн энэ ноцтой мэдэгдэл өнөөдрийн эдийн засгийн бодит байдал уу, эсвэл дараагийн нүхээ ухах гэсэн улс төрийн шоу төдий юу гэдгийг ялгахад бэрх. Төсвийн үрэлгэн зардлыг тэвчиж төрийн өмчит компаниудын дарга нарын цалинг хасч хэмнэлт хийх шийдвэр гаргасан атлаа дэд сайд гэх ямар ч хэрэггүй албан тушаалыг дахин бий болгож төсөвт дарамт учруулав. Зээлийн хүүг бууруулж, аж ахуйн нэгжүүдийг татвараас чөлөөлөх шийдвэр гаргасан атлаа бодлогын хүүг нэмэгдүүлж нөгөө гараараа тэдний хүзүүнд олс углаж орхив. Энэ мэтээр нэг гараар хийснээ нөгөө гараараа устгаж буй Засгийн газар, Сангийн яам, Монголбанк ямар гэгчийн замыг сонгоод буйг хэлэхэд эрт байна. Энэ бүхний төгсгөлд улсаа тэр чигээр нь барьцаанд тавьж олон улсаас валют зээлж, өөрсдөө ямар ч шийдвэр гаргах эрхгүйгээр барьцаалагдах "Стэнд бай" хөтөлбөрт хамрагдахаас өөр арга алга хэмээн мэдэгдэл хийвэл гайхах зүйл үгүй болох нь ээ.

> ...Зээлийн хүүг бууруулж, аж ахуйн нэгжүүдийг татвараас чөлөөлөх шийдвэр гаргасан атлаа бодлогын хүүг нэмэгдүүлж нөгөө гараараа тэдний хүзүүнд олс углаж орхив...

ӨӨР ӨНЦӨГ

# АЧАА ТЭЭШИНДЭЭ Л ЭЗЭН БАЙЯ






Урин дулаан зуны улиралд Монголыг зорих гадны жуулчдын хөл ихэсдэгтэй зэрэгцээд гадны улс орнуудаар аялах монголчуудын цуваа ч тасардаггүй. Энэ хэрээр Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудалд зорчигчдын урсгал хавраас намар хүртэл эрс нэмэгддэгтэй холбоотойгоор ажилчид нь өндөр хариуцлага хүлээн ажилладаг гэж хэлж болно. Ачаалал ихэслээ гээд анхаарлаа сулруулж болохгүй. Ялангуяа бусдын тээшийг санамсаргүй байдлаар өөр хэн нэгэн андуурч гарахаас урьдчилан сэргийлж, онгоц буусны дараа зорчигчид тээшээ авах үед дугаараар нь тулгаж гаргадаг нь гадны зарим зорчигчийн дургүйцлийг хүргээд авдаг ч ингэхээс өөр арга байдаггүй байна. Учир нь санамсаргүй тохиолдлоор эсвэл санаатайгаар бусдын тээшийг өөр нэгэн зорчигч авч гарвал тээшээ алдсан хүн аманд орсон тоогоо хэлж хохирол барагдуулахыг шаарддаг. Ийм тохиолдол манайд үйл ажиллагаа эрхэлж байгаа авиакомпаниудад нэг биш удаа тохиолдож байсан тул Монголд ирсэн зорчигч бүрийн тээшийг гарт нь гардуулахаас наагуур нягт тулгаж байж гаргахаас өөр аргагүй байдаг байна. Тэгвэл гадны бусад орнуудын нисэх онгоцны буудалд ийм хяналт байхгүйн улмаас он гарсаар тээшээ алдсан нийт зургаан удаагийн тохиолдол Бээжин болон Сөүлийн нисэх онгоцны буудалд гарчээ. Азаар тэдгээрийн ихэнхийнх нь тээш олдсон байна. Тодруулбал, хүний тээш андуурч авч гарснаа мэдээд тухайн нисэх онгоцны буудлын тээшний хэсэгт буцаан хүргэж өгдөг бол зарим нь огт ор сураггүй алга болжээ. Бусдын тээшийг андуурч авахаас урьдчилан сэргийлэх хяналт гадны нисэх онгоцны буудлуудад байхгүй байгааг тухайн улсын соёлтой холбож ойлгож болно. Хүний тээшийг санаандгүй андуурч авлаа гэхэд буцаагаад тээшний хэсэгт нь хүлээлгээд өгчихдөг соёл нэвтэрсэнтэй ч холбоотой байж болох юм. Гэвч энэ нь зарим нэгэнд завшаан болж бусдын ачааг боловсон аргаар хулгайлах боломжийг бүрдүүлээд байгаа юм. Тиймээс та болон таны ойр дотны хүн харь орныг зорин нисэх гэж байгаа бол өөрийн ачаа тээшиндээ эзэн болж онцгой содон тэмдэг наалт наахад илүүдэхгүй юм. Гадны улс орнуудын аль ч нисэх онгоцны буудлын ажилчид Чингис хаан нисэх онгоцны буудал шиг таны тээш мөн эсэхийг шалгаж гаргахгүй учир өөр нэгэн андуурч авах магадлалтай гэдгийг дахин сануулъя. Ийм төрлийн асуудал үүсвэл тухайн нисэх онгоцны буудлын тээшний хэсэгт хандах хэрэгтэй бөгөөд холбогдох журмаар зорчигчийн өргөдөл гомдлыг үндэслэн зорчигчийн ачааг тээвэрлэсэн авиакомпани алдагдсан тээшний кг тутамд 20 ам.долларын нөхөн олговрыг төлж хохирол барагдуулна хэмээн тусгажээ. Өөрөөр хэлбэл, нисэх буудлаар үйлчлүүлж байгаа иргэд бусдын ачаа тээшийг авч гарч байгаа эсэхэд хяналт тавьдаггүй гадны орнуудын уг системийн хариуцлагыг тухайн ачаагаа алдсан зорчигчийг тээвэрлэсэн авиакомпани хүлээхээс өөр аргагүй тэр журмын хүрээнд тээшээ алдсан зорчигч өргөдөл гомдол барьж гүйх болж байгаа юм.

Одоо хичээл сургуулийн цаг ч хаянд ирлээ. Эх орондоо амарсан дэлхийн монголчууд маань Улаанбаатараас Бээжин, Сөүл, Москва, Токио, Хонконг, Берлин гээд дэлхийн өнцөг булан бүр рүү цаг нартай уралдан ажил хичээл рүүгээ буцацгааж байна. Ахин сануулья ачаа тээшиндээ эзэн болоорой. Алдчихлаа гэхэд андуурч авсан хүн нь буцааж өгөөч үү, үгүй ч үү. Тиймээс ачаа тээшиндээ л эзэн байя.

# ДЭЛХИЙ

## ЭРДОГАН 38 МЯНГАН ХОРИГДЛОО “ӨРШӨӨВ”



Б.ДАВААХҮҮ

Одоогоос сар гаруй хугацааны өмнө Туркийн цэргийн зарим албан тушаалтнууд төрийн эргэлт хийхийг оролдсон. Гэсэн ч тэдний өдүүлсэн тэмцэл хотын иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсны улмаас хагас өдрийн дараа бүтэлгүйтлээр төгссөн билээ. Энэ үеэр нийтдээ 240 хүн амь үрэгдсэн бөгөөд тэдний дунд хотын гэм зэмгүй иргэд олноороо багтаж байжээ. Цэргийн эргэлттэй холбоотойгоор эдүгээг хүртэл хэдэн арван мянган цэргийн алба хаагч баривчлагдан саатуулагдаж, төчнөөн тооны төрийн алба хаагчид ажлаасаа халагдсан бол харин гол удирдагчийг нь АНУ-д орогнож буй шашин судлаач Гюлен хэмээн Туркийн тал хардаж байгаа. Тэгвэл Ресеп Тайип Эрдоган дээрх баривчилгааны дараа шоронд хоригдож байсан 38 мянган ялтныг суллах шийдвэр гаргажээ. Цэргийн эргэлттэй холбоотойгоор олон хүнийг хоморголож баривчилсныхаа дараа ийнхүү бусад гэмт хэрэгтнүүдийг суллаж байгаа нь цаанаа учир шалтгаантай гэж үзэх судлаачид ч байна. Туркийн Хууль зүйн сайд Бекир Боздаг сэтгүүлчдэд өгсөн мэдэгдэлдээ өнгөрсөн сард болсон цэргийн эргэлтийн дараа гаргасан онц байдал тогтоох тухай зарлигийг дагаж гарсан шинэ хуулийн дагуу энэ жилийн зургадугаар сарын сүүлчээс өмнө гэмт хэрэгт холбогдож, шоронд хоригдсон хэрэгтнүүдээс 38 мянгыг нь тодорхой нөхцөлтэйгөөр суллах чиглэлийг өгсөн гэж ярьсан байна. Гэхдээ терроризм, хүн амины хэрэг, хүчингийн хэрэг үйлдэж шоронд хоригдсон гэмт хэрэгтнүүдэд уг заалт хамаарахгүй аж. Бикер Боздаг уг арга хэмжээ улс орны аюулгүй байдал муудаж буйтай огт хамаагүй гэдгийг мөн онцолсон байна. Туркийн Засгийн газар цэргийн эргэлтийг шашин судлаач Гюлины талынхан үйлдсэн гэж үзэж байгаа. Тэд эдүгээг хүртэл 20 гаруй мянган цэрэг, цагдаагийн байгууллагын алба хаагчдыг баривчлан хориод буй юм. Туркийн Засгийн газар ямар шалтгаанаар 38 мянган хоригдлоо суллаж буй нь хараахан тодорхойгүй байгаа ч, орон нутгийн зарим мэдээллийн сайтууд илүү олон хүнийг хоморголон баривчлах зорилготой үйл ажиллагаа хэмээн хардаж байна. Туркийн Засгийн газрын хувьд цэргийн эргэлтийг лалын хэт даврагч бүлэглэлийн удирдагч, шашин судлаач нэрт сэтгэгч Гюлен Фетхуллахыг хөшигний араас удирдсан хэмээн хардаж, түүний орогнож буй АНУ-аас түүнийг өөрийн улсын талд шилжүүлэн өгөхийг шаардсан. Гэвч АНУ-ын тал одоогийн байдлаар эл асуудалд тодорхой хариулт өгөхөөс татгалзах болсноор хоёр улсын харилцаа улам бүр муудсаар байгаа юм. Түүнчлэн Прокурорын газраас АНУ-д орогнож буй Гюленд бүх насаар нь хорих ял болон 1900 өдрийг чанга дэглэмтэй хорих ангид өнгөрүүлэх ялыг төлөвлөсөн байдаг.

> ...Туркийн Засгийн газар ямар шалтгаанаар 38 мянган хоригдлоо суллаж буй нь хараахан тодорхойгүй байгаа ч, орон нутгийн зарим мэдээллийн сайтууд илүү олон хүнийг хоморголон баривчлах зорилготой үйл ажиллагаа хэмээн хардаж байна...

## Монголд 2085 оны олимп болох уу




Таван тивийн улс үндэстнийг хэл соёл, шашин шүтлэг арьс өнгөний ялгаварлалгүйгээр нэгэн хүсэл тэмүүлэл, зорилго дор нэгтгэж чаддаг энх тайвны бэлгэдэл болсон Олимпийн наадмыг 2085 онд манай улс зохион байгуулах магадлал тун өндөр байгаа тухай Их Британийн нэгэн сэтгүүлд тэмдэглэгджээ. Зуны Олимпийн их наадмыг 2085 он хүртэлх хугацаанд зохион байгуулах боломжтой хот баруун Европт найм байгаа бол Азид ердөө хоёр хотоор хязгаарлагдаж байгаа аж.

Тэр нь Киргизийн Бишкик болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар. “The Lancet” сэтгүүлийн гаргасан судалгаагаар дэлхийн дулаарал зуны олимпод нөлөөлөх хэмжээнд хүрсэн гэсэн дүн гарсан аж. Судалгаанд дулаарлын улмаас хэзээ хаана ямар байдлаар олимпийг зохион байгуулах вэ гэдгийг тооцоолоход саад учруулж, том асуудал үүсгэж байгааг онцолсон байна. Наадмыг зохион байгуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө цацах хэдий ч тэмцээн болох үед олимп цуцлагдах хэмжээний цаг агаарын аюулт үзэгдэл болж болзошгүй гэнэ. Судалгааг хотуудын дулааны температур болон чийгшлийн үзүүлэлтүүдийг харгалзан явуулсан бөгөөд гадаа зохион байгуулагддаг спортын төрлүүд хамгийн эрсдэлтэй аж. Ялангуяа марафоныг тэд онцолж байна. Тиймээс уг судалгааны дүнгээр дулаарлын улмаас томоохон хотууд Олимп зохион байгуулах эрхтэй хотын жагсаалтаас хасагдаж, Улаанбаатар хотод олимп болж магадгүй нь.

## Хойд Солонгосын Элчин сайд Сөүлд орогножээ

Хойд Солонгосын Их Британид суух Элчин сайдын орлогч гэр бүлийнхээ хамтаар Сөүлд орогнож буй тухай Өмнөд Солонгосын Засгийн газраас мэдээллээ. Албаны эх сурвалжийн мэдээлснээр Лондонд суух Пхеньяны хоёрдугаар Элчин сайд Тэ Ён Хо эхнэр хүүхдийнхээ хамт эдүгээ Сөүлд амьдарч байгаа гэнэ. Сэтгүүлчдэд өгсөн мэдээлэлдээ Өмнөд Солонгосын Эв нэгдлийн яамны хэвлэлийн төлөөлөгч Жон Жун Хе “Тэд одоо Засгийн газрын хамгаалалтад байгаа. Холбогдох хүмүүстэй шаардагдах үйл ажиллагааг явуулж буй” гэж ярьсан байна. Гэхдээ тус улсын гадаадын иргэний улсдаа түр хугацаанд орогнуулах дүрэмд тусгасан зүйл заалтыг хангаж байгаа эсэхийг асуусан асуултад хариулахаас татгалзжээ. Мөн “Манай улсад орогнож буй шалтгааныхаа тухайд Тэ Ён Хо удирдагч Ким Жон Уны дэглэмийг эсэргүүцэж, Өмнөд Солонгос улсын чөлөөт ардчилсан нийгэмд амьдрахын хүссэний зэрэгцээ өөрийн үр хүүхдийнхээ ирээдүйг бодож ирсэн гэж тайлбарлаж байгаа” хэмээн өгүүлсэн байна.

## Онгоцонд төрсөн нярайг сая фунтаар мялаав

Арабын нэгдсэн Эмират улсын Дубай хотоос Филиппинийг чиглэн хөөрсөн “Себу Пакифик” нисэх онгоцонд зорчиж явсан нэгэн жирэмсэн эмэгтэй нислэгийн явцад гэнэт өвдөж, хүүхдээ төрүүлжээ. Онгоц Филиппинд газардах ёстой байсан ч, жирэмсэн эмэгтэй гэнэт өвдөж эхэлснээр Энэтхэгт ослын буулт хийхэд хүрсэн аж. Энэ мэдээлэл тус онгоцонд зорчиж явсан Мисси Берберабе Умандал гэгчийн фэйсбүүк хуудаснаа нийтэлсэн постоос тодорхой болсон юм. Жирэмсэн эмэгтэй найман сартай байсан бөгөөд төрөх хугацаа нь болоогүй байжээ. Гэвч онгоц хөөрсний дараа гэнэт өвдөж эхлэхэд айж, гайхсан зорчигчид бүсгүйд туслахыг шаардан сандралдсан байна. Азаар зорчигчид дунд хоёр эмч байж таарч, бүсгүйд тусламж үзүүлэн төрүүлжээ. Ингээд онгоцонд бяцхан охин дуу хадаан мэндэлсэн байна. Эх ч ямар нэг хүндрэлгүй амаржжээ. Харин зорчигчдын дунд нулимс дуслуулах хүмүүс олон байсан гэнэ. Шинэхэн төрсөн нярайг нисэх багийн гишүүд болон эмч нар усаар угааж, зорчигчдын нэгийнх нь авч явсан хүүхдийн хувцсыг өмсүүлжээ. Нисгэгчид ээж, охин хоёрт эмнэлгийн тусламж үзүүлэхээр Энэтхэгийн Хайдерабад мужийн нисэх онгоцны буудалд ослын буулт хийсэн байх бөгөөд эх хүүхдийн биеийн байдал сайн байгаа гэнэ. Онгоцонд нь шинэ нярай төрсөн баярт үйл явдлыг тохиолдуулан “Себу Пакифик” авиа компани дотоодын нислэгээр 10 мянган удаа үйлчлүүлэх эрхийн бичиг нэг сая фунтыг бэлэг болгон өгсөн байна. Одоогоор хэн гэгч эмэгтэй онгоцонд төрсөн нь нууц байгаа юм.

## Японы Ерөнхий консулын байранд гал гарлаа

Өмнөд Солонгосын өмнөд этгээдийн Бусан хот дахь Японы Ерөнхий Консулын газрын байранд гал гарчээ. Гал орон нутгийн цагаар өчигдөр өглөө гарсан байна. Одоогоор галын шалтгааныг тодруулахаар Ерөнхий консулын газрынхан ажиллаж байгаа тухай Эн Эйч Ки агентлаг мэдээлжээ. Гал өчигдөр өглөө 06:00 цагийн үед гарсан байна. Байрны дотор талаас утаа гарч байгааг цагдаагийнхан анх олж харжээ. Дараа нь Консулын газрын хашааны дотор талд байрлах хог хаях хэсэгт байрлуулсан моднууд шатаж эхэлсэн байна. Галыг тэр даруй яаралтай унтраасан бөгөөд азаар гэмтэж бэртсэн хүн байхгүй гэнэ. Хэргийн дараа цагдаагийн байгууллага Консулын газрынхнаас байцаалт авсан тухай холбогдох байгууллага мэдээлсэн байна. Мөн хяналтын камерыг шалгахад сэжигтэй зүйл илрээгүй аж.

## Густав Малерын гар бичмэлийг худалдана

Сонгодог хөгжмийн ертөнц дэхь аугаа хөгжмийн зохиолч Густав Малерын маш ховор хөгжмийн бүтээлийн гар бичмэлийг дуудлагаар худалдахаар болжээ. Дуудлага худалдааг Хонконгод “Сотебис” компани зохион байгуулах юм байна. Нийт 232 хуудас бүхий Густав Малерын өөрийн гараар бичиж үлдээсэн “Resurrection” симфони энэ удаа зарагдах гэнэ. Энэ жил Их Британийн Лондонд болсон дуудлага худалдаагаар сонгодог хөгжмийн гар бичмэл түүхэндээ хамгийн их буюу 3.5 сая фунт стирленгийн үнэ хүрч байсан юм. Тиймээс Густавын бүтээл тус амжилтыг эвдэж магадгүй байна. Австрийн хөгжмийн зохиолч, удирдаач тэрээр амьдралынхаа туршид 10 гаруй симфонийг бичсэн байдаг бөгөөд өмнө нь нэг ч удаа түүний бүтээлийг худалдаж байгаагүйг зохион байгуулагчид онцолжээ.




УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

# О.Отгонбаяр:

Э.ТУУЛ

*“Эрдэнэт үйлдвэр”-ийн төрөлжсөн архив “А” үнэлгээ авсан талаар Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”-ийн Захиргаа хүний нөөцийн хэлтсийн орлогч дарга О.Отгонбаяртай ярилцлаа.*



# “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”-ИЙН ТӨРӨЛЖСӨН АРХИВ “А” ҮНЭЛГЭЭ АВСАН

**-“Эрдэнэт үйлдвэр”-ийн төрөлжсөн архив “А” үнэлгээ авсан гэсэн. Улсын хэмжээнд явагдсан архивын шалгалт хэдий хэр хугацаанд үргэлжилж, дүнгээ гаргасан бэ?**

-Монгол Улсын Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, төрийн архивуудын үйл ажиллагааны төвшинг тогтоож, дүгнэлт хийх, цаашид авах арга хэмжээний зорилт чиглэлийг тодорхойлж, шийдвэрлүүлэхэд чиглэгдсэн зорилго бүхий улсын үзлэг Хууль зүйн сайдын 2016 оны А/43 тушаалаар аймаг нийслэлийн 22 архив, төрөлжсөн 12 архив, бүгд 34 төрийн архивын үйл ажиллагаанд 2016 оны дөрөвдүгээр сараас зургадугаар сарын хугацаанд явагдаж, дүнгээ гаргасан. Улсын үзлэгээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Компанийн болон төрөлжсөн архивын хамт олны сүүлийн долоон жилийн хөдөлмөрийн үнэлгээ 97.2 оноо буюу “Маш сайн” гэж үнэлүүллээ. Мөн төрөлжсөн архивуудаас улсын хэмжээнд II байр эзэлсэн амжилт гаргалаа.

**-Танай төрөлжсөн архив сүүлийн долоон жил шинэлэг ямар ажил хийв?**

-Архивын сан хөмрөгийг баяжуулах, түүхэн ач холбогдол бүхий үнэт баримт цуглуулах, компанийн ажилтнууд, иргэдэд сурталчлах зорилгоор хэд хэдэн томоохон арга хэмжээнүүдийг зохион явууллаа. Үүний нэг нь “Түүхээ бичье” уралдаан. Цех, нэгжүүдийн түүх нь архивын сан хөмрөгийн данс бүртгэл боловсруулах, хөмрөгийн түүхчилсэн лавлах үйлдэх, сан хөмрөгийг тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэхэд өндөр ач холбогдолтой ажил болсон. Энэ ажлын хүрээнд 30 орчим цех, нэгжүүдийн бүрэн түүх, 2544 тусгай төрлийн баримтуудыг (гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгүүд, баримтат кино г.м) архивт хүлээн аваад байна. “Эрдэнэт үйлдвэр”-ийн түүх бол хүний түүх. Тэгэхээр хүний түүхийг авч үлдэх нь маш үнэ цэнэтэй юм. “Эрдэнэт үйлдвэр”-ийн үүсэл, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Д.Жаргалсайхан, Д.Жигмэдцэрэн, Төрийн соёрхолт, геологич С.Сандуйжав, Төрийн соёрхолт, Техникийн шинжлэх ухааны доктор, дэд профессор, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий баяжуулагч Ж.Баатархүү, гавьяат уурхайчин Д.Цагаач, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн профессор, Техникийн шинжлэх ухааны доктор С.Даваанямн нарын 230 хувийн баримтаар хөмрөг үүсгээд байна. Мөн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, томоохон өргөтгөлийн төслүүдийн тайланг төлөвлөгөөний дагуу Төрөлжсөн архивт хүлээн авах ажил хийгдэж байна.

**-Хүмүүс аль нэг байгууллагын архив бол лавлагаа, тодорхойлолт өгдөг л газар гэж ойлгодог шүү дээ?**

-Тийм шүү. Ер нь архив хаалттай байгууллага байсан. Тэтгэвэрт гарах хэн нэгэн лавлагаа авдаг газар байсныг л бид мэднэ. Харин манайх 2014 оноос компанийн цех, нэгжүүдийн дунд “Архивын нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж, уламжлал болгоод байна. Энэхүү нээлттэй өдөрлөгийн хүрээнд цех, хэлтсүүдийн удирдлага, хүний нөөц, бичиг хэргийн ажилтан, компанийн топ удирдлагууд, компанийн таван цех болон Орхон аймгийн ЗДТГ, Нийгмийн даатгал, Татварын хэлтэс зэрэг 10 гаруй албан байгууллага, Булган, Орхон аймгийн залуу сэтгүүлчид гээд нийт 300 гаруй хүнд ажлаа сурталчлаад байна. Мөн 2014 оноос хойш нийт 13 удаагийн үзэсгэлэн зохион байгуулж, давхардсан тоогоор 260 баримтыг дэлгэн үзүүлсэн. Манай Төрөлжсөн архивт ОХУ-аас компанийн түүхтэй холбоотой цаасан суурьтай 10 үнэт хадгаламжийн нэгж, зургаан гэрэл зургийн цомог зэрэг үнэт баримтуудаас сан хөмрөгөө арвижууллаа.

**-Цахим архивтай болсон гэсэн үү?**

-Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баримтыг тоон системд шилжүүлэх ажил хийгдсэн. Үүний зэрэгцээ үйлдвэрт ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа ажилтан бүрийн ажилд орсон, гарсан тушаалаас гадна шилжилт хөдөлгөөнийг хайлтын цахим санд оруулах томоохон ажлыг компанийн удирдлагын дэмжлэгтэйгээр гүйцэтгэж байна. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр баримтын хадгалалт хамгаалалт сайжирч, эрэлт хайлт түргэн шуурхай болох олон давуу талтай.

**-Архиваас жилдээ ямар хэмжээний үйлчилгээ авдаг вэ?**

-Төрөлжсөн архив маань жилдээ 1400 тушаалын, 2200 цалингийн лавлагаа, 2300 баримтын хуулбарыг иргэдэд гаргаж өгч, уншлагын танхимаар 800 гаруй баримтаар үйлчилдэг. Мөн 3500 баримтыг үдэж хавтасладаг.

**-Танай Төрөлжсөн архивт ямар ховор, нандин, үнэт баримтууд хадгалагддаг вэ?**

-“Эрдэнэт үйлдвэр”-ийн ерөнхий захирлын хамгийн анхны 01 дугаартай тушаал 1974 оны долдугаар сарын 27-ны өдөр Дархан хотод гарсан байдаг. Ерөнхий захирал В.Шлыков үүрэгт ажилдаа орсон тухай. Тэр үед үйлдвэрийн захиргаа Дархан хотод байрлаж байсан. Мөн Эрдэнэт хот, “Эрдэнэт үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын нийт 1038 ширхэг гэрэл зурагтай зургаан цомог, Эрдэнэтийн овоог анх 1965 онд нээсэн Монгол-Чехословакийн геологийн экспедицийн судалгааны баримтууд зэрэг олон ховор, нандин баримтууд бий. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 1981 онд “Эрдэнэт үйлдвэр”-ийн Засвар механикийн заводад ажилд орж байсан тушаал, “Эрдэнэт үйлдвэр”-ийн анхны хөрс хуулалтаар олдсон 3325 гр жинтэй цул аранжин зэс зэрэг баримтууд ч архивын сан хөмрөгт хадгалагдаж байдаг.

**-Одоо Төрөлжсөн архивт зайлшгүй хийх шаардлагатай ямар ажил байгаа вэ?**

-Цаашид улам сайжруулах, хэрэгжүүлэх шаардлагатай хэд хэдэн ажил бий. Үүнд, компанийн баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж мэргэжлийн төвшинд ажиллах, орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангагдсан архивын зориулалттай байртай болох асуудлыг шийдвэрлүүлэх, түр баримтыг хадгалах Байгууллагын архивын үйл ажиллагааг жигдрүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах гэх мэтчилэн шийдвэрлүүлэх хэд хэдэн ажил байна.

# Хэн юу хэлэв

Э.МӨНХ

Сонгуулиар үнэмлэхүй олонхи болсон МАН-ынхан өнгөрсөн долоо хоногт томилгоогоо үргэлжлүүлж, Монгол Улсын эдийн засаг тартагтаа хүртэл муудаж, цалин мөнгөө тавьж чадахгүйд хүрсэн тухай Ерөнхий сайд, Сангийн сайд нар нь мэдээлж, хэмнэлт, таналтын тухай ярьж өнжив. АН-ынхан ч дуугүй суусангүй, ээлжит бус чуулганы хуралдааныг яаралтай зарлаж, төсвийн тодотголоо хэлэлцэх талаар шаардлага хүргүүлсэн. “Мэргэжлийн” гэх тодотголтой шинэ Засгийн газар ч мөн хуралдаж, төрийн өмчит байгууллагын дарга нарын цалингаас хасч, төсөв хэмнэх шийдвэр гаргасан. Мөн өнгөрсөн долоо хоногт Бразилийн Рио-Де-Жанейро хотноо зуны олимпийн XXXI наадам үргэлжилж, монгол тамирчдаа дэмжих хүмүүсийн уухай тасарсангүй, одоо ч үргэлжилж байна. Ингээд өнгөрсөн долоо хоногт олны анхаарлыг татсан зарим хүний ярьсныг “Хэн юу хэлэв” булангаараа онцлон хүргэж байна.







## Ж.Ганбат: ТАХ-ын цалинг бууруулахад гурван тэрбум төгрөг хэмнэнэ

*/Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга/*

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат болон Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар мэдээлэл хийхдээ төрийн албан хаагчдын цалинг бууруулж, төсөвт хэмнэлт хийнэ хэмээн мэдэгдсэн. Энэ талаар Сангийн яамны төсвийн бодлогын газрын дарга Ж.Ганбат “Сангийн яамаас төсвийн тодотгол боловсруулж байгаа. Төрийн өндөр болон улстөрийн албан тушаалтнууд, яамд, агентлагийн удирдах албан тушаалтнуудын цалинг тодорхой хувиар бууруулах тухай асуудал яригдаж байна. Асуудлыг ойрын үед Засгийн газарт танилцуулж, УИХ-д өргөн мэдүүлнэ. Орон нутгийн Засаг болоод ИТХ-ын дарга нар, нийслэлд агентлагийн даргаас дээш албан тушаалтнууд энэ хэмнэлтэд хамрагдана гэсэн үг. Харин эдгээрээс доош төвшний төрийн албаныхны цалин хөндөгдөхгүй байх үүргийг Ерөнхий сайдаас өгсөн. Улстөрийн болон төрийн өндөр албан тушаалтнуудын цалинг 30 хувь, төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын цалинг 20 хувиар тус тус бууруулна. Энэ оны хувьд нийлээд гурав орчим тэрбум төгрөг, ирэх жилд найм орчим тэрбум төгрөг хэмнэгдэнэ. Мөн цалин бууруулахаас гадна үйл ажиллагааны зардлыг бууруулна. Үүнд, тэвчиж болох бүх зардлыг бууруулна. Тодруулбал, гар утас, тээвэр шатахууны зардлыг бууруулж, тавилга эд хогшлыг худалдаж авахыг зогсооно. Урсгал засварыг бууруулна. Зочин төлөөлөгч хүлээж авах зардлыг бууруулах арга хэмжээг авна. Гар утасны зардлаас гэхэд жилдээ 100-200 сая төгрөг хэмнэнэ” хэмээсэн юм. Харин Засгийн газрын хуралдаанаар хамгийн түрүүнд албан тушаалтнуудын цалин хөлсийг хасах асуудлыг хэлэлцээд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон бусад удирдлагын цалин хөлс, урамшууллын хэмжээг өөрчлөн тогтоож, нэг сарын цалин хөлс нь 5-10 сая төгрөг бол 30 хувь, 10-30 сая төгрөг бол 50 хувь, 30 сая төгрөгөөс дээш бол 60 хувь бууруулахаар болсон юм. Мөн эдгээр албан тушаалтны урамшууллыг олгохдоо үр дүнгийн гэрээний биелэлттэй сайтар уях, байр орон сууцны нөхцөл сайжруулах, нэг удаагийн буцалтгүй тусламж зэрэг бусад их хэмжээний мөнгөн шагнал бүхий нэмэлт хангамж олгохыг зогсоохоор шийдвэрлээд байна.

## З.Нарантуяа: Хэзээ ч, аль ч улс валютынхаа нөөцийг ил тод зарладаггүй

*/УИХ-ын гишүүн, УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга/*

УИХ-ын гишүүн, УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга З.Нарантуяа Сангийн сайдын хийсэн мэдээллийн талаар байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувиар өөрийнхөө байр суурийг илэрхийлье. Мэдэгдлийг анхааралтай харж, сонсож, судалсан. Үүнээс шинэ байгуулагдсан Засгийн газар болоод түүний Сангийн сайд бол өнөөдрийн эдийн засагт үүсээд байгаа нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийг давж туулах өөрсдийн гэсэн арга зам, гарцаа олж чадаагүй юм байна гэж харлаа. Мэдэгдлийг нь багцлаад дүгнэх юм бол явж явж өнөөдрийн төсвийн алдагдлыг нөхөх, хүндрэлтэй зарим төслүүдээ санхүүжүүлэх, графикийн дагуу төлөх зээлийн төлбөрийг төлөхдөө олон улсын байгууллага эсвэл түншлэгч орнуудаас зээл авахаас өөр аргагүй байдалд хүрээд байна. Зээл л авч үүнийг шийдэх юм байна гэсэн санааг энэ мэдэгдлээрээ хийж байна. Сангийн сайдын дурьдсан гадаадын хөрөнгө оруулалт буурсан, эдийн засгийн өсөлт 17 хувиас уруудсан, улсын валютын нөөц багассан болоод өр төлбөрийн тухай тоо бол шинэ тоо биш. Энэ бол 2012-2014 онд одоогийн МАН-ын нэрийн өмнөөс УИХ-д нэр дэвшиж УИХ-ын гишүүн болсон Сангийн сайд Ч.Улааны үед ч, 2014 онд томилогдож 2015 оны есдүгээр сар хүртэл ажилласан одоогийн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатыг Сангийн сайд байх үед ч, АН-аас томилогдсон Б.Болор сайдын үед ч яригдаж л байсан тоонууд. Нөхцөл байдал ийм байна шүү, бид шийдлээ яаж олох вэ гэдэг дээр тухайн үеийн Ерөнхий сайд Ч.Сайханбилэг УИХ-д мэдэгдлээ байнга хийж явсан. Гарцаа хайхын тулд УИХ-д олонхи болсон хоёр нам хамтарч УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийг баталж байлаа. Өнөөдөр гэнэтхэн энэ тоонуудыг шинэ Ерөнхий сайд, Сангийн сайд гарч ирээд мэдсэн юм шиг ард түмнийг цочролд оруулахаар өндөр дуугаар ярих шаардлагагүй.

Түүнээс гадна хүндрээд байгаа эдийн засагт хүндрэл болохоор мэдэгдлүүдийг Монголбанк, Сангийн яамны зүгээс хийж байгаа нь нөхцөл байдлыг улам муутгаж болзошгүй байгаа учраас мэргэжлийн хүний хувьд маш их санаа зовж байна. Яагаад гэвэл Монголбанкны ерөнхийлөгч бол мэргэжлийн бус улс төрийн мэдэгдэл хийсэн. Хэзээ ч, аль ч улс валютынхаа нөөцийг ил тод зарладаггүй. Холбооны нөөцийн банкны дарга ямар үг хэлэхээс эдийн засгийнх нь нөхцөл байдал хамаарч байдаг. Тэр хүний хэлсэн үгнээс үүсэх үр дагавар их байдаг. Эдийн засаг савлаж, доргиж болно. Монголбанкны ерөнхийлөгч ийм хэмжээний мэдэгдэл хийлээ. Зохиомол валютын хомсдолыг бий болгох алхам хийсэн нь туйлын харамсалтай. Ер нь Сангийн сайд дөрвөн жилээр, Монголбанкны ерөнхийлөгчийг зургаан жилээр томилдог нь бодлогын хувьд нэг нэгнээ хянах, төсвийн тэлэлт, мөнгөний нийлүүлэлтийг хэт их байлгаж эдийн засгийг савлуулахгүй байх зорилготой байдаг. Ийм атал Монголбанкны ерөнхийлөгч хүн улстөрч шиг ийм мэдээлэл хийсэн нь туйлын харамсалтай. Гарцын хувьд энэ Засгийн газар 100 хоногтоо ямар гарц гаргаж ирэхийг сөрөг хүчин ажиглаж байгаа. Цаг нь болохоор санаа оноогоо УИХ, Засгийн газарт тавих болно” гэжээ.

## Д.Банди: Манай шүүгч олигтой хамгаалалт хийсэнгүй

*/Монгол Улсын Ардын багш, гавьяат дасгалжуулагч/*

Рио-2016 олимпийн наадамд манай улсаас зургаан боксчин оролцож, зарим нь шүүгчийн буруу шүүлтээс болж, Д.Отгондалай амжилтаасаа хасуулсан талаар цахим ертөнцөд нэлээд шуугисан. Тэгвэл энэ талаар “Олимпт эрх авч оролцдог болсноос хойш зургаан боксчин оролцсон нь хамгийн олон ширэн бээлийтэн оролцсон наадам боллоо. Сайн байна гэж гэж харж байгаа. Тамирчдын маань хувьд сайхан байсан. Эрх авах тэмцээнүүдэд сайн тоглосон. Олон улсын чанартай томоохон тэмцээнүүдэд ч сайн оролцсон. Бэлтгэлжилт овоо байсан гэж бодож байгаа. Би өмнө нь ч хэлж байсан. Ямар амжилт гаргах бол гэдэгт хоёр л юм байгаа. Нэгдүгээрт, дасгалжуулагчид хэр зэрэг тактик зохиож чадна вэ. Тамирчин түүнийг нь хэр гүйцэтгэж чадаж байна вэ. Хоёрдугаарт, тамирчныхаа амжилтыг хамгаалах шүүгчтэй байгаа. Шүүгч маань хэр хамгаалалт хийж чадаж байна вэ гэдгийг хэлж байсан. Энэ маань сая харагдлаа. Д.Отгондалайгийн хувьд сайхан тоглосон. Идэвхи, хурд, дайчин байдал, өөрөө эхэлж ажилласан зэрэг нь сайн. Гэтэл шүүгчид дандаа эсрэг талд оноо өгсөн. Манай шүүгч олигтой хамгаалалт хийсэнгүй. Хамгаална гэдэг нь хүнтэй яриа хөөрөөтэй байж, наануу цаануу болж харилцахаас эхлээд байна. Тэгж чадсангүй. Дараагийн тоглолт бол финалд Бразилийн тамирчинтай тоглох байсан. Д.Отгондалай маань түүнтэй өмнө нь хоёр таарч хоёуланд нь ялсан. Гэтэл нөгөө талаас асар их арга хэмжээ авсан байна. Дандаа өөрсдийн талын шүүгчдийг суулгасан байна. Тэр байтугай Бразилийн шүүгч хажуугийн шүүгчээр сууж байгаа юм. Энэ нь манай тамирчин ялагдах нэг шалтгаан болсон. Дутуу оноо өгөх бас нэг шалтгаан манай талаас гарсан. Яасан бэ гэвэл, Д.Отгондалай маань тактиктай ажиллаагүй. Үзэгч харахад түрүүлж ажиллаад, илүү байгаа. Гэтэл манай хүн зүгээр л зодох гээд дайраад. Тэгээд зодсон. Зодоход нь мань хүнийг ингэдэг юм байна, ингэхээр ингэе, тэгэхээр нь тэгье гээд тоглолтыг нь эртнээс судалчихсан эсрэг тал тактиктай ажилласан. Яаж тоглох ёстой байсан бэ гэвэл, баруун гарын эсрэг угтуулдаг цохилтыг шахаж явж байгаад зогсоох ёстой байсан. Манай хүн ажиллана, баруун гар шиднэ, тэр нь оногдоод байсан. Шүүгч эхлээд цохисныг биш сүүлд цохисныг нь хардаг байхгүй юу. Эсрэг талын тактикт орчихлоо, судлагдсан гэдгээ анхаарч үзсэнгүй алдаа гарлаа. Спорт хөгжиж байгаа орнуудад тамирчин ямар шагнал авч байна, түүнтэй тэнцэх хэмжээний шагналыг дасгалжуулагчид нь өгдөг. Тэгж байж дасгалжуулагчийг шаардах, шахах үүргийг бий болгоно. Энэ манайд дутагдаад байна” гэжээ.

## МЭДЭЭЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# МИНИЙ НААДАМ ОЙРЫН 100 ЖИЛДЭЭ БОСОО ЯВАХ ААРХАЛ ӨГЛӨӨ...!

МОНГОЛ НААДАМ ӨЧИГДӨР ШӨНӨ 12 ЦАГ 58 МИНУТ ХАВЬЦАА ӨНДӨРЛӨВ ҮҮ...? ҮГҮЙ ЮУ...? МИНИЙ НААДАМ ЛАВ ӨЧИГДРИЙН 00:00 ЦАГААС ЭХЭЛЛЭЭ...!

Учир нь, ойрын 10 гаруй жил арын сайхан хангайн алдраа дуурсгасан бөхийн бах жаахан дутаад явлаа л даа!

Наадам болгонд хүлээдэг заан дүү маань наана цаанах "чөдөр"-өөс болоод долоо давуутаа л уначихаад, түүнийг нь дагаж мань мэт сэтгэлээр унаж...наадам өндөрлөөгүй байхад л миний "наадам" дуусчихаад болдоггүй байв...?

Эдүгээ дархан аварга болсон Өсөхөө дүү маань бас л "Заан" цолтой гацчихаад нэлээд хэдэн жил зовоож билээ...?

Даян аварга "Буур" хэмээх алдартай Нацагийн Жамъян аваргын 100 жилийн ойг тэмдэглэн Цахир суманд наадах үеэр

...ӨСӨХӨӨ МИНЬ

ӨС...ӨС...

ӨӨДӨӨ ДҮРЭЛЗЭН

АС...АС...!...хэмээн агсарсан шүлгээ умшин амьхандаа ааг нэмэх гэж ядаж явлаа. Эл шүлгээ цаасан дээр бичгийн машинаар бичээд өчнөөн хувилаад нутгийнхаа наадамд тарааж ч явлаа...!

...За яах вэ...тэг тэгсээр Өсөхөө маань зайтай, завсартай... дөрөв дараалж түрүүлсээр...арслан нэг жил...тэгээд л ойчино...аварга нэг жил...тэгээд л унана... даян аварга нэг жил... бас л сунаад өгнө... далай аварга нэг жил...дараа жил нь өвдөглөөд өгнө... нутгийнхаа дүү нарыг балиашиглах шиг балай юм үгүй юм билээ?...

За яах вэ...тэг тэгсээр Өсөхөө маань зайтай, завсартай...дөрөв дараалж түрүүлсээр...арслан нэг жил...тэгээд л ойчино...аварга нэг жил...тэгээд л унана...даян аварга нэг жил...бас л сунаад өгнө... далай аварга нэг жил...дараа жил нь өвдөглөөд өгнө...нутгийнхаа дүү нарыг балиашиглах шиг балай юм үгүй юм билээ?

Харин яах вэ...эдүгээ Өсөхөө дүү минь МОНГОЛ УЛСЫН ДАРХАН АВАРГА цолтой болж дотрыг минь уужруулав...!

Даанч түүнийг ирлээд өгдөг таван халуун "заан" нөхөд нь үгүй тул мохоо нэгэн болоод байгаа ч монгол бөхөө яах аргагүй чимж, өнгөлж явааг бахдам!

Дашрамд хэлэхэд, Өсөхөө маань хэд хэдэн аймгийн бөхөд цол ахих, бяр нэмэх буян үйлдээд унаад өгдөг байсан юм шүү!

Сүхбат өөрөө ам мэхээр хуурах гэж байж сарваганаж байгаад өшиглүүлснийг өчигдрийн наадамтай цуг бид мартах нь ээ!

Хаа байсан дөрвийн даваанд Дундговийн Пүрэвжав, Завханы Бадам-Очир, тавын даваанд Ховдын Батзаяа, зургаагийн даваанд Говь-Алтайн Соронзонболд, есийн даваанд Увсын Ганбат...гээд хэчнээн ч бөхөд цол бэлэглээ билээ...?

Тэр болгонд өөрөө цолоор ухраад л яваад байсныг наадамчид мэдэх байлгүй дээ...?

Тэр болгондоо Өсөхөө маань уйлаад хэвтчихдэг байсан уу...?

Хөөрхий хөх үдээр шиг царайлчихаад л тахимаа тахийсхийж өгчихөөд л яваад өгдөг байгаагүй бил үү...?

Олон наадамчид, нутгийнхан харин хажуугаас нь зөндөө "уйлсан" даа!

Харин хариуд нь цол ахисан бөхөөрөө хөөрөөд л явсан олонхи аймгийнхан Өсөхөөд маань "Баярлалаа" гэж хэлж байсныг би лавтай сонсоогүй ээ!

Мөн үүн шиг Санжаадамба дүү минь их л олон жил зовж явсаар арай чүү "Заан" хэмээх чөдрөөсөө салж, зангаргаа харуулсан аварга боллоо!

Би мөн л Өсөхөө дүүгээ олон жил хүлээж цөхсөн шигээ Санжаа дүүгээ цөөнгүй жил хүлээж аргаа бараад бас л

...Бос ...бос...

Зодгоо чангалан бос...

...Тэс...тэс...

Зоригоо чангалан тэс... хэмээн бичиж явсаар өчигдөр л нэгмөсөн сэтгэлээ амраалаа!

Санжаа маань чихээ хазуулчихаад, амаа яз татуулчихаад, цусаар будуулчихаад унахдаа "Луйвардууллаа" гэж ганц ч удаа хэлж байл уу...?

Харин ч энэ бүхнийг тэсээд л өнгөрүүлсэн!

Хажуугаар нь хэдэн ч муу шаврай нар цол ахиж, наадмын түрүүнд хүрлээ дээ!

Тэр болгонд арын сайхан хангайнхан амьтан хүнийг муулж ам хэлээ "билүүдээ" бил үү?

Төрийн наадмын дэвжээг цусдаж, нулимсдаж, нулимж яв луу...?

Архангайнхан даанч уужуу аажуу, айван тайван гэдгээрээ улс даяараа алдартай нь л үнэнээс үнэн юм даа!

Тэглээ гээд манай нутгийн бөхийн жудаг арилсангүй ээ!

Тэнгэрийн дорх буян заяа минь дундарсангүй ээ!

Улсдаа цолтой бөхийн тоогоороо магнайлсаар...!

Одоо нэг дархан аварга...нэг даян аварга...гурван аваргатай боллоо!

Арслангаараа тэргүүлэн аархсаар л явна аа!

Хамгийн олонтаа шөвгөрсөн Мижиддорж арслан амьд явна!

Хамгийн олон үзүүрлэсэн Мөнх-Эрдэнэ арслан архайсаар явна!

ЭНЭ ЖИЛ УЛСЫН ЦОЛЫГ САМАР ШИГ ТҮҮЛЭЭ!

Дөрвөн начинаар бас л аймгуудыг тэргүүллээ! Цаана нь цөөнгүй шижигнэсэн аймгийн арслан тав давахын босгон дээр өвдөглөснийг тоолоод үзээрэй...!

Даанч бие биеэ тэгтлээ улайран дэмжээд байдаггүй нь бас "АРХАНГАЙ ЗАН" юм даа!

Аварга, арслан зэрэг түрүүлж үзүүрлэснээрээ бас л манлайллаа!

Бод л доо!

Улсад хоёр бөх нь зэрэгцэн үзүүр түрүүнд хүрсэн рекордыг хэзээ, хэн эвдэх вэ?

1922 онд Луу гүний Г.Вандан аварга, Хан-Өндөр буюу Ихтамирын улсын арслан Д.Далантай

1947 онд "Аат" Д.Лувсанжамц, "Суумгай" хэмээх Содов / улсын арслангууд/ 1926 онд даян аварга "Буур" гэгч Н.Жамьян, улсын арслан Ш.Төмөрбаатар / хоёул Тариат, Цахир залгаа сум/ 1962 онд Улсын арслан Д.Жамц, улсын заан Ж.Чойжилсүрэн / хоёул Хотонт, Өлзийт залгаа сум/ 2016 онд саяхан Улсын заан Ч.Санжаадамба, улсын өсөх идэр начин Пүрэвдагва нар дээрх уламжлалаа давтаж 1024 бөхөөс шовойж, Улсын аварга, улсын арслан гэх хүндтэй цолыг гуйж бус гуядаж авлаа!

Юунд бухимдана вэ?

Бусад аймагт ч ийм аз тохиосон наадам бас бий!

1959 онд Хөвсгөл аймгийн дархан аварга Д.Дамдин, улсын хурц арслан Ц.Бадамсэрээжид 1970 онд Мөн Хөвсгөл аймгийн дархан аварга Д.Дамдин, аварга Ч.Бээжин нар дээрх амжилтыг давтжээ.

Тэгвэл 1976 онд Төв аймгийн улсын арслан Д.Хадбаатар, улсын арслан П.Дагвасүрэн 1982 онд Увс аймгийн дархан аварга Х.Баянмөнх, улсын арслан М.Мөнгөн нар тус тус нэг удаа энэ амжилтыг гаргажээ!

Ийм амжилт амархаан олдохгүй ээ!

Элдэв хэл ам, хэтэрсэн хийрхлээр бол бүүр ч авчихдаг амны хишиг бус аа!

Үүнийг өнөөдрийн хэрүүлээр турхирагчид сайтар болгоон бодож...хэл амаа билүүдвээс, хийрхэл амьсгаагаа бэлбүүрдвээс зохилтой!

Дээд даваа байтугай доод даваанд унаж л байдаг хорвоо!

Харин ч хайнцлаа хө гээд хар хоргүйшууддахиадбарилдчихвал монгол бөхийн байтугай жирийн л эр хүний жудаг шүү дээ!

Ер нь ч хүүхэд биш дээ...том цолтой бөх байж уйлж хэвтээд л ...хэндээ эрхлээд туниад байгаа юм бэ?

Наадамчдаа хүндэлж сураагүй хүнийг бөх гэх үү,

Наадмаа хайрлахгүй байгаа нь хүн чанар мөн үү...?

Ариун дагшин дэвжээгээ цусддаг, нулимдаг, нулимсддаг, сүүлдээ хэрүүлээр бузартуулдаг араншин хэнээс, хаанаас гараад байна вэ?

Улсад олон түрүү авлаа...улсад олон түрүү авья гэж бодож буй бол эхлээд дэвжээгээ цэвэр байлгаж, сэтгэлээ цэвэрлэмээр байна шүү!

Уйлсан бөх бол өөрийгөө бус нутгаа л нулимсдаж, нулимж, цусдаж буйгаа мэдэх үү?

Нутаг яах вэ гээд хар амиа хоохойлж байгаа бол Монгол улсынхаа төрийн наадмыг гутааж байна гэдгээ л бодчих...?

Бодох ухаангүй бол зодгоо тайлаад нусны алчуур болгочихоод шуудгаараа нулимсаа арчаад сууж байвал таарна шүү...!

### АВАРГА, АРСЛАН ХОЁР ДҮҮДЭЭ ААРХАЛ НЭМЭХ ШҮЛЭГ

Нар нуугдаж ичингүйрэн
Сар шургаж бишүүрхэн
Одод үргэж анивчин
Олныг шуугиулж ханаруулан
Омог огшоосон барилдаантай
Домог оршим наадам боллоо

Ард олны хүлээсэн
Аатай заан дүү минь
Алга загатнуулан хөлрөөсөн
Аварга цолондоо хүрлээ!
Аймаг сумаараа талцсан ч
Аархуу заан хүү минь
Ад зэд, аз ээ хослуулсаар
Арслан, аварга цол зэрэгцүүлэн хүртлээ!
Мэдээ орсон цагаасаа мэдэхийн
"Мэдээ" унших наснаасаа мэдэхийн
Улсын наадамд нэг аймгийн хоёр бөх
Уухай цуурайтуулан уулга алдуулан
Үзүүр түрүүнд цугтаа хүрч байсныг
Үзэж дуулсан цаг хэдэнтээ тохиосон...!
Түрүүлсэн нь аварга болж
Үзүүрлэсэн нь арслан хүртэж
Түмнийхээ хайрыг булаасан түүхийг
Үзсэн, сонссон домог ч бас бийсэн...!
Даамай ЗААН цолоороо наадмаа чимж
Гоомой унахдаа наадамчин олноо чилээж
Шаврай бөхөд цолоо алдсаар явсан ч
Шаавай дүү Санжаадамба минь санасандаа хүрлээ!
Одоо дүүгийн минь Од нь гийчихлээ!
Олноо баясгасан Хийморь нь гэрэлтчихлээ!
Даваа бүхэндээ тордоггүй цаг нь ирчихлээ!
Дархан аварга болохын цондон нь сэргэчихлээ!
Түрүү булаахдаа ганцаараа булаасангүй ээ!
Түмнийхээ дунд домог үлдэхээр булаалаа!
Үзүүр өгөхдөө ганцаараа шовойсонгүй ээ!
Үзэгчдийнхээ дунд омог үлдээхээр цоройлоо!

Далан жил тасарсан Бурхдын хутагтай наадам
Данշиг сэргэсэн буяны жудагтай наадаанд
Ар халхын аварга Вандангийнхаа сүнсийг сэргээж
Арслан цол хүртэн түрүүлж бахархал дэврээсэн
Булган хайрханы өвөрт эвшээж төрсөн хүү минь
Бурхан Зонховын өлмийд эрхэлж өссөн дүү минь
1024 бөхөөс босоо үлдсэн хийморioroo
Мянган жилд ч давтагдашгүй хос арслан цол хүртлээ!
Монгол Улсын төрийн наадмын арслан
Модон шоголт даншиг наадааны арслан
Эр бярынхаа агаар хослуулан хүртсэн
Эгнэшгүй ийм домгийг хэн амилуулах вэ?
Заяын гэгээний мутар зулайд нь хүрч
Заяатай мэнгэний адис зулагт нь ивсэн
Пүрэвдагва нэр нь тарни мэт
Пүрэвийн лог шиг сүр нь равнай мэт
Ааг бяр нь ханахын дээдээр ханасан
Аатай мэхээрээ хийцийн сайхнаар хийцлэсэн
Улс, даншгийн хос арслан цолыг
Увс, халхын хүчтэй бүхнээс булаасан
Арын хангайн бөхийн домгоо сэргээсэн
Аархуу дүү Пүрэвдагваараа ахиад нэг аархья...ах нь!

Тайхар чулуу өргөсөн бөхийн домогтой
"Бөх билэгт" дэвжээний минь хийморь сэргэлээ!
Тайшир, Алтай таван богд, Хан хэнтийн эрчүүлийн омгийг дарж
Бөхийн удмаараа аархдаг нутгийн минь лундаа эргэн ирлээ!
Аварга цол нь атганд нь ааг нэмэх Санжаадамба дүү минь
Арслан цол нь аагинд нь аархал нэмэх Пүрэвдагва хүү минь
Ар халхад цуутай бөхийн домгийг сэр ээ...сэр ээ...!
Аль ч цагт яригдах аархуу омгийг сэргээ...сэргээ...!
2016...07...12...02 цаг
...07...13...06 цаг дор аархлаа асаан омогшвоо.

*Улаанбаатар хот. Гацууртын Шар хоолойн Хүрэн уулын өвөр дэх улаан халзат өргөөнөө...*

МЗЭ-ийн шагналт яруу найрагч Жигмэдийн БАТСАЙХАН

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ШУУРХАЙ МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС БОЛГООМЖИЛ

Энэ оны нэгдүгээр сараас гарч эхэлсэн хонины цэцэг өвчний тархалт буурахгүй байна. Одоогийн байдлаар уг малын гоц халдварт өвчин Дорнод, Дорноговь, Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий аймгийн найман суманд өвчний голомт бүртгэгджээ. Тус өвчний тархалтыг зогсоохын тулд холбогдох мэргэжлийн байгууллагууд хотоос гарах товчоонд ариутгал, халдваргүйтгэл хийж, зарим аймагт хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна.

## Төрийн өмчийн цэцэрлэгүүдийг хамран сургах тойрог батлагдлаа

Нийслэлийн Боловсролын газрын даргын тушаалаар цэцэрлэгүүдийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах зорилгын хүрээнд төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хамран сургах тойргийг баталжээ. Тус тойргийн хүрээнд 2016-2017 оны хичээлийн жилийн төрийн өмчийн цэцэрлэгийн элсэлтийг зохион байгуулж ажиллахыг дүүргүүдийн боловсролын хэлтсийн дарга, цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус үүрэг болголоо. Дашрамд дурдахад, сургууль, цэцэрлэгийн бүртгэл ирэх даваа гарагт эхэлнэ. Энэ жил сугалаа явуулахгүйгээр ганцхан өдөр бүртгэх юм байна.

## Өнөөдөр элэгний өвчлөлийн талаар мэдээлэл өгнө

“Оном” сангаас Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарынханд зориулж үйл ажиллагааныхаа талаар цогц мэдээлэл өгөх нээлттэй өдөрлөг зохион байгуулахаар болжээ. Өдөрлөг өнөөдөр 10:00-20:00 цагийн хооронд “Оном” сангийн байранд болох юм байна. Өдөрлөгт оролцсоноор сэтгүүлчид “Оном” сангийн санаачлан хэрэгжүүлж байгаа Элэг бүтэн Монгол хөтөлбөр, элэгний эмгэг өвчинтэй тэмцэх, хепатитын вирусийг эрт илрүүлэн эмчилж, элэгний хавдар, хатуурлын шалтгаант нас баралтыг эрс бууруулах зорилго бүхий оношилгоо, эмчилгээ, судалгаа, эрдэм шинжилгээ, анагаахын эрдэм судлалын цогцолбор Элэгний төвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах ажээ. Нээлттэй өдөрлөгт оролцон бүх хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад Элэгний төвд элэгний В, С вирусийн түргэн тестийн шинжилгээг үнэ төлбөргүй хийлгэх эрх олгохын дээр элэгний төвийн эмчид үзүүлж, зөвлөгөө авах эрхийн бичиг мөн элэгний хатуурлын зэрэг тодорхойлох оношилгоонд 50 хувь хөнгөлөлттэй үнээр хамрагдах эрхийн бичиг, “Оном” бүрэн дунд сургуульд 10 хувийн хөнгөлөлттэй хүүхдээ сургах эрхийн бичиг зэргийг олгох гэнэ.

## Хүчингүйд тооцов

Балдан овогтой Цэнд-Аюушийн Хан-Уул дүүрэг, 8-р хороо сонсголонгийн 12-504 тоотын хашаа байшин эзэмших эрхийн гэрчилгээг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

# Ц.ЖАРГАЛАНТУУЛ: ЦЭЦЭРЛЭГИЙН БҮРТГЭЛИЙГ СУГАЛААГААР ЯВУУЛНА

Н.БАТЗАЯА

*Нийслэлийн Боловсролын газраас цэцэрлэгийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах талаар өчигдөр хэвлэлийн бага хурал хийлээ. Энэ үеэр НБГ-ын сургалт арга зүйн хэлтсийн дарга Ц.Жаргалантуулаас зарим зүйлийг тодрууллаа.*

**-Энэ жил цэцэрлэгт шинээр хэчнээн хүүхэд бүртгүүлэх вэ. Цэцэрлэгийн тоо нэмэгдсэн үү?**

-Өнгөрсөн хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд нийт 91687 хүүхэд цэцэрлэгт хамрагдлаа. Үүнээс 69428 хүүхэд нь төрийн өмчийн, 22259 нь хувийн цэцэрлэгт хамрагдсан байдаг. Төрийн өмчийн 233, төрийн бус 399 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлж ажиллалаа. Харин энэ жилийн тухайд гэвэл төрийн өмчийн 31 цэцэрлэгийн шинэ болон өргөтгөлийн барилга ашиглалтад орж, 3990 хүүхэд цэцэрлэгт явах боломжтой болсон. Мөн 44 хувийн цэцэрлэг шинээр ашиглалтад орж, 2225 хүүхэд цэцэрлэгт явах боломж бүрдсэн. Нийт 6115 хүүхэд шинээр цэцэрлэгтэй болно гэж ойлгох хэрэгтэй. Гэхдээ энэ бол шинээр нэмэгдсэн цэцэрлэгийн орон тоо гэдгийг анхаарах хэрэгтэй. Харин нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсрол эзэмших шаардлагатай 145 мянган хүүхэд бий. Үүнээс энэ жил 101 мянган хүүхдийг цэцэрлэгт хамруулах бодлого барьж ажиллаж байгаа.

**-Цэцэрлэгийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах вэ. Сугалаагаар явуулахгүй гэж байсан шүү дээ?**

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон Улаанбаатар хотын Захирагчийн “Хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангах тухай” албан даалгавар гарсан. Төрийн өмчийн цэцэрлэгүүд дээд хүчин чадлаараа ажиллаж байгаа болович нийгмийн эрэлт хэрэгцээнээс хамаарч тулгамдсан асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаа. Тиймээс “Төрийн өмчийн цэцэрлэгт бүртгэх тухай” зөвлөмж гаргалаа. Уг зөвлөмжид дүүргийн боловсролын хэлтсүүд, цэцэрлэгийн ажлын хэсэг, эцэг эхчүүд юу хийх ёстой вэ гэдэг талаар нарийн тусгасан. Нийслэлийн хэмжээнд хоёр настай 19 мянган хүүхэд бий. Үүнээс 9750 хүүхдийг цэцэрлэгт элсүүлэх боломжтой гэсэн судалгаа бий. Үлдсэн хүүхдүүд хувийн цэцэрлэгт элсэх боломжтой. Ер нь нийслэлийн цэцэрлэгийн тоо байнга нэмэгдэж байгаа хэдий ч шилжилт хөдөлгөөн, төрөлтийн хэмжээнээс шалтгаалан иймэрхүү нөхцөл байдал үүсч байна. Бүртгэлийн хувьд, өмнө нь цэцэрлэгт явж байсан хүүхдүүд үргэлжлүүлж суралцана. Зөвхөн 2014 онд төрсөн хүүхдүүдийг шинээр бүртгэх ёстой. Бүртгэлийг наймдугаар сарын 22-25-нд ажлын цагаар зохион байгуулна. Мөн нийслэлийн хэмжээнд хэд хэдэн цэцэрлэгүүд ачааллатай ажилладаг. Хамран бүртгэх тойргийг нь зааж өгсөн ч гэсэн хамрагдаж чадахгүй тохиолдол бий. Иймээс элсэлтийн тасалбарыг тараана. Элсэлтийн тасалбарын тусламжтайгаар наймдугаар сарын 26-нд сугалаа зохион байгуулна. Өнгөрсөн жил нийслэлийн 44 цэцэрлэгт сугалаагаар бүртгэх ажлыг хэрэгжүүлж байсан. Мөн амьжиргааны төвшингөөс доогуур орлоготой, 3-аас дээш хүүхэдтэй, хагас болон бүтэн өнчин хүүхдийг хорооны нийгмийн ажилтны тусламжтайгаар цэцэрлэгт хамруулна. Түүнчлэн таван настай хүүхдийг бүгдийг нь хамруулах бодлого барьж ажиллаж байгаа. Үүнээс цэцэрлэгт хамрагдах боломжгүй бол хувилбар сургалтад хамруулдаг. Гэхдээ сургуульд элсэх учраас таван настай хүүхдийг цэцэрлэгт элсүүлэх бодлого барина.

**-Элсэлтийн тасалбараа яаж авах вэ. Эцэг, эхчүүд аль хэдийнэ дугаарлаад эхэлсэн шүү дээ?**

-Дугаарлах шаардлага байхгүй. Наймдугаар сарын 22-25 хүртэл гурав хоногийн хугацаа бий. Энэ хугацаанд хүссэн үедээ очоод хүүхдээ бүртгүүлээд элсэлтийн тасалбараа авч болно. Учир нь эхний удаа ирсэн хүүхдүүдийг бүртгэж, тасалбар олгоно. Үүний дараа сугалаа явуулж, цэцэрлэгт явах эрх үүснэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Тиймээс хонон өнжин дугаарлах хэрэг байхгүй.

**-Ес болон аравдугаар сард төрсөн хоёр настай хүүхдийг авахгүй гэсэн. Энэ үнэн үү?**

-Үгүй. 2014 онд төрсөн бүх хүүхдийг авна. Төрсөн сар ямар ч хамаагүй.

**-Гурав, дөрвөн настай хүүхдийг цэцэрлэгт авах боломжгүй гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Энэ хичээлийн жилд 2014 онд төрсөн бүх хүүхдийг цэцэрлэгт бүртгэнэ. Өнгөрсөн жил 2013 онд төрсөн хүүхдүүдийг бүртгэсэн. Ер нь нэг бүлэгт 15-20 хүүхэд байх ёстой. Гэтэл бид 40 хүүхэдтэй байхаар шийдвэрлээд байна. Ингэхээр хүүхэдтэй ажиллах орчин нөхцөл талаасаа хэцүү шүү дээ. Багшийг 40 хүүхэдтэй ажилладаг гээд нэг төгрөг ч илүү өгдөггүй. Тэгэхээр цэцэрлэгийн ачаалал хүнд байна. Бид аль болох цэцэрлэгийн насны хүүхдийг бүгдийг нь хамруулах арга хэмжээ авахыг зорьж ажилладаг. Энэ жил тодорхой цэцэрлэгүүдэд 3-4 настай хүүхдийг элсүүлэх элсэлтийн тоо бий.

**-Байгууллагын цэцэрлэгийг ажиллуулна гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу?**

-Цэцэрлэгийн хүрэлцээтэй байдлыг хангахын тулд хэрэгжүүлж байгаа хэд хэдэн ажлын нэг нь байгууллагын цэцэрлэг юм. Байгууллагуудаас ч гэсэн цэцэрлэг ажиллуулъя гэдэг саналыг ирүүлсэн. Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 80 хүүхэд, Гадаад харилцааны яам 70 хүүхдийн цэцэрлэг байгуулъя гэдэг санал ирүүлсэн. Бид үүнийг дэмжиж ажиллана. Ойролцоо улсын цэцэрлэгийн бүлэг байхаар зохицуулах юм. Ер нь цаашид шинээр баригдах барилга, томоохон компаниудыг байгууллагын цэцэрлэгтэй болох шаардлагыг тавина.

**-Хувийн компаниуд цэцэрлэг байгуулах боломжтой юу. Байгууллагын цэцэрлэгийг хэрхэн дэмжих вэ?**

-Хоол, хувьсах зардлын мөнгийг төрөөс гаргана. Харин тогтмол зардлаа тухайн байгууллага өөрөө хариуцна.

**-Жил бүр сургууль, цэцэрлэгийн бүртгэлтэй холбоотой хээл, хахуулийн асуудал гардаг. Үүнд ямар хяналт тавьж ажиллах вэ?**

-Энэ асуудлыг шийдэхийн тулд сугалаагаар бүртгэж байна. Үүнд бүртгэл хариуцсан комиссууд хяналт тавьж ажиллана. Бидний гаргасан зөвлөмжид ямар нэгэн мөнгө, хандив авахгүй байх талаар тусгагдсан.

PHOTO NEWS



*Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох цэргийн багуудын бие бүрэлдэхүүн өчигдөр Жанжин тугандаа ёслон хүндэтгэл үзүүллээ. Энэхүү ёслолд Монгол Улсын Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж, ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал Д.Ганзориг нар оролцсон. Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох цэргийн бүрэлдэхүүн энэ удаад Афганистан болон Уганд ад үүрэг гүйцэтгэнэ. Манай улсаас нийт 100 гаруй алба хаагчид оролцох юм.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

## Согтуу жолооч хүн мөргөж, амийг нь хөнөөжээ

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож байх үедээ хүн мөргөж улмаар амийг нь хохироосон хэрэг гарчээ. Тодруулбал, Чингэлтэй дүүргийн нутаг Шадивлангийн замд марк дугаар тодорхойгүй авто машины жолооч нь явган зорчигч 41 настай эрэгтэй Э-г мөргөж, амийг нь хөнөөгөөд хэргийн газраас зугтжээ. Замын цагдаагийн алба хаагчид шуурхай ажилласны үр дүнд “Patrol” маркийн авто машины жолооч З нь согтуурүулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон уг хэргийг үйлдсэн болохыг олж илрүүлсэн байна. Мөн Налайх дүүргээс хойш 21 дэх километрт Тэрэлжийн “Агуй хад” гэх газар асфальтан зам дээр “Mark-2” маркийн Э жолоочтой авто машин онхолдож, жолооч 28 настай эрэгтэй Э амиа алдсан хэрэг гарчээ.

## Хүүхэд харах үйлчилгээнд 3000 хүүхэд хамрагдах боломжтой

2016 оны нэгдүгээр сарын 1-нээс “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хууль хэрэгжиж эхэлсэн. Ингэснээр гэртээ ганцаараа үлддэг олон хүүхэд сургуулийн өмнөх боловсролыг эзэмших боломжтой болсон. Тэгвэл ХАХНХЯ-аас өнгөрсөн хугацаанд нийслэлийн хэмжээнд 765 хүүхэд харагчийг бэлтгэсэн байна. Үүнээс 389 хүүхэд харагч нь байрны дүгнэлтээ гаргаж, үйлчилгээгээ эхэлжээ. Одоогийн байдлаар 1885 хүүхэд “Хүүхэд харах үйлчилгээ”-нд хамрагдаж байгаа бөгөөд есдүгээр сарын 1-нд 3000 хүүхэд уг үйлчилгээнд хамрагдах боломжтой аж.

## Сургуулийн орчинд эргүүл ажиллуулна

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгийн хүрээнд эцэг, эхчүүд эргүүлд гарах ажээ. Тодруулбал, нийслэлийн Засаг даргын захирамжаар 2016 оны наймдугаар сарын 24-ний өдрөөс есдүгээр сарын 15-ны хооронд “Сургууль орчмын эргүүл”-д ажиллах эцэг эхчүүд, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад туслах ажилтан, олон нийтийн цагдаагийн ажилтан, эргүүлийн цагдаа томилохыг Улаанбаатар хотын цагдаагийн газар, Замын цагдаагийн газарт даалгажээ. Мөн эргүүлчдийг явган хүний гарц, гарамтай хэсгүүд дээр ажиллуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, хараа хяналтгүй замын хөдөлгөөнд оролцож байгаа хүүхдүүдэд тавих хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулах юм байна.

## Буцалсан усанд хүүхэд түлэгдэж, хүнд гэмтжээ

Эцэг, эхчүүдийн хараа хяналт сул байдлаас үүдэн бага насны хүүхдүүд буцалсан ус, халуун тогоотой хоолонд түлэгдэх явдал гарсаар байна. Энэ сарын 17-нд Өмнөговь аймгийн Ханхонгор суманд гэртээ байсан зургаан настай хүү буцалсан халуун усанд түлэгдэж, хүнд гэмтжээ. Одоогийн байдлаар хүүгийн биеийн байдал муу байгаа бөгөөд ГССҮТ-ийн Түлэнхийн тасагт хэвтэн эмчлүүлж байгаа аж. Тиймээс Цагдаагийн байгууллагаас эцэг, эхчүүдийг хүүхэд тавих хараа хяналтаа сайжруулж, халуун тогоо, буцалсан ус зэргийг хүүхдээс хол байлгахыг анхааруулаа.

## Мөнгөн аяга хулгайлж байгаад баригдав

Айлын гэрт орж, мөнгөн аяга хулгайлж байгаад баригдсан хэрэг гарчээ. Тодруулбал, энэ сарын 17-нд Сонгинохайрхан дүүргийн есдүгээр хорооны оршин суугч 58 настай эрэгтэй Г нь Баянгол дүүргийн тавдугаар байрны ... тоот айлд түлхүүр тааруулан орсон байна. Тэрбээр, хоёр ширхэг дунд гарын мөнгөн аяга, “Жи мобайл”-ын модем хулгайлж байгаад үйлдэл дээрээ баригдсан аж. Тус хэргийг Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэс хөдөлгөөн хийж, хэргийг шалгаж байгаа юм байна. Сүүлийн үед хулгайн гэмт хэрэг ихсэх болсон байна. Өнгөрсөн лхагва гарагт гэхэд Цагдаагийн газарт хулгайн гэмт хэрэгтэй холбоотой 27 дуудлага иржээ.

ЗАВСАРЛАГА

Rio2016



# ИЧО КАОРИ

## Олимпийн наадамд дөрөв дараалан түрүүллээ

Б.ДАВАА

Бразилын нийслэл Рио де Жанейро хотноо болж буй хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлгэдэл Олимпийн наадам 13 дахь өдрөө үргэлжилж байна. Спортын 28 төрлөөр дэлхийн улс гүрний шилдэг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, гал бутарсан тоглолтууд үргэлжилсээр. Энэ удаагийн Олимпийн тамирчид хэд хэдэн төрлөөр дэлхийн дээд амжилтыг эвдэж, шинэ аварга, шинэ амжилтууд спортын түүхийн хуудаснаа бичигдэн үлдсээр байна. Энэ буухиаг ч Японы чөлөөт бөхийн амьд домог суут бөх Ичо Каори үргэлжлүүлж, тэрбээр дөрвөн олимп дараалан алтан медаль хүртсэн анхны эмэгтэй тамирчин болж, чөлөөт бөхийн түүхэн дэх амьд домог гэдгээ батлан харуулж чадлаа. Чөлөөт бөхийн эмэгтэйчүүдийн 58 кг-ийн жинд зодоглосон Ичо Каори Риогийн олимпийн алтан медалийн төлөө ОХУ-ын алдарт тамирчин Валерия Сергеевна Кобловаг ялж, аваргалсан юм. Олимпоос дөрвөн удаа алт авсан эмэгтэй бөх түүнээс өөр байхгүй. Эрэгтэй тамирчдыг оруулж тооцвол, усан сэлэлтийн Майкл Фелпс, уртын харайлтын Карл Льюис, зээрэнцэг шидэлтийн Альфред Ортер, Бен Эйнсли, Пол Элстром нарын суут зургаан тамирчин Олимпийн наадмуудад дараалан алт хүртсэн байдаг.



1984 онд төрсөн эдүгээ 32 настай дэлхийн 10 удаагийн аварга тамирчин бүсгүй 2004, 2008, 2012 оны Олимпод нэг ч ялагдалгүй алтан медаль хүртсэн бол энэ оны олимпод ч суут аварга гэдгээ батлан дахин чөлөөт бөхийн дэвжээг эзэгнэлээ. Тамирчин хүний хувьд анхны амжилт нь хэзээ ч мартагддаггүй болов уу. Ичогийн хувьд анх 2002 оны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс анхны алтан медалиа хүртэж байжээ. Түүний эгч ч гэсэн бөх. Чихару Ичогийн хувьд 2004 болон 2008 оны зуны Олимпийн чөлөөт бөхийн 48 кг-ийн жинд зодоглож мөнгөн медаль хүртэж байсан бөгөөд эдүгээ их спортоос аль хэдийнэ зодог тайлж, дүүгийнхээ барилдааныг үзэгчийн суудлаас харж байгаа юм. Риогийн олимп болохоос хоёр жилийн өмнө буюу 2014 оны наймдугаар сард Ичогийн гэр бүл хагацал үзсэн. Түүний ээж өвчний учир хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн бөгөөд шийдвэрлэх барилдааны дараа бүсгүй тэнгэрт одсон ээж нь түүнд дэмжлэг үзүүлсэн тухай нүдэндээ нулимстай өгүүлжээ. “Би ээжийгээ маш их санаж байна. Намайг тэнгэрээс харж байгаа байх аа. Сүүлчийн хоёр оноог бурхан болсон ээж минь надад өгсөн. Надад тэгэж л санагдаж байна” хэмээн ярьжээ. Түүний хувийн амьдрал тун нууцлагдмал юм билээ.

Японы хэвлэлд түүнийг найз залуутай гэж бичсэн байгаа ч, үнэндээ нөхөр болох хүнийх нь фото зураг бараг үгүй. Тиймээс ч ганц бие гэж хүмүүс ойлгодог аж. Гэхдээ түүнд найз залуу бий гэнэ. Чөлөөт бөхийн суут тамирчны сэтгэлийн эзэмдэж чадсан азтай эр бол Солонгос хүн. Өмнөд Солонгосын мөн л чөлөөт бөхийн дасгалжуулагч Чэ Ван Хо гэгч аж. Хосууд 2007 онд Азийн наадмын үеэр танилцаж, түүнээс хойш үерхэж эхэлжээ. Гэхдээ хуримын зар өдий болтол дуулгаагүй тэднийг салсан гэх таамаг байгаа хэдий ч, бүсгүй тун удахгүй хуримын зар дуулгах биз. Эцэст нь тэмдэглэхэд, энэ оны нэгдүгээр сард ОХУ-д болсон И.Ярыгины нэрэмжит тэмцээнд манай бөхөд ялагдан 13 жил үргэлжсэн цуврал ялалтаа тасалсан хэдий ч, Ичо Каоригийн хүч чадал хариагүй байна. Магадгүй 2020 оны Токиогийн олимпоор тэр чөлөөт бөхийн дэмжээнд зодоглохыг үгүйсгэх аргагүй.

### Хазүхито Сакаэгийн ялалтын поз





Риогийн зуны олимпийн эмэгтэй 48, 58, 69 кг-ийн жингийн чөлөөт бөхийн барилдаанд Японы гурван тамирчин аваргалж, Наран улсын алтан медалийн тоог ахиуллаа. Тэгвэл Риогийн дэвжээний хамгийн азтай, адтай дасгалжуулагч ч мөн Японоос тодрох нь тэр. Тэр бол Японы алдартай чөлөөт бөхийн дасгалжуулагч Казүхито Сакаэ. 1983-1989 онуудад ААШТ, ДАШТ-үүдэд 62 кг-ийн жинд зодоглож, хэд хэдэн мөнгөн медалийг хүртсэн тэрбээр эдүгээ гавьяаныхаа амралтад сууж, үе үеийн шилдэг тамирчдыг төрүүлэн гаргасаар байна. Түүний шавь суут бөхчүүдийн нэрс Саори Ёшида, Каори Ичо, Хитоми Обара, Эри Тосака гээд л хөвөрнө.

Нэгэн үдэш гурван шавь нь алтан медаль хүртсэн Казүхито дасгалжуулагчид шавь нар нь ч томоохон хүндэтгэлийг үзүүлсэн юм. 48 кг-ийн жинд аваргалсан Эри Тосака Азарбайжаны бөх Мария Стадникийг ялж, алтан медаль хүртсэнийхээ дараа мөрөн дээрээ дасгалжуулагчаа суулгаж, наран улсын далбааг намируулан дэвжээгээ тойрон гүйсэн нь олимпийн торгон агшин байлаа. Тэгвэл энэ явдлын дараа 69 кг-ийн жинд зодоглож, ОХУ-ын бөх Наталия Воробиеваг ялж аваргалсан Сара Дошо ч мөн түүнд хүндэтгэл үзүүлэн дээрх байдлыг давтсан. Өмнө нь 2008 оны Олимпод Саори Ёшида алтан медаль хүртэхэд Казүхито Сакаэ мөн л ийм поз авч байв. Гэхдээ тухайн үед тэрбээр өөрөө шавиа мөрөн дээрээ суулган баярлаж байлаа. Ямартай ч, Риогийн олимпийн нэгэн торгон агшин Японы дасгалжуулагч Хазүхито Сакаэгийнх байсан гэдэгтэй уншигчид маань санал нийлэх биз.

### Дэлхийн хамгийн хурдан эмэгтэй

Дэлхийн хамгийн хурдан хүн бол Усэйн Болт. Хэдийгээр түүний амжилтыг гүйцэхгүй ч, дэлхийн хамгийн хурдан эмэгтэй гэсэн тодотголыг мөн л Ямайкийн тамирчин Элайн Томпсон хүртэж байна. Түүний хувьд “Рио 2016” Олимпийн наадмын хөнгөн атлетикийн эмэгтэйчүүдийн 200 метрийн ангилалд оролцож, 21.78 секунтэд хурдлан хоёр дахь олимпийн алтан медалиа авав. Тэрбээр наймдугаар сарын 13-нд эмэгтэйчүүдийн 100 метрийн ангилалд 10.71 секунтээр түрүүлсэн юм. Түүний араас Нидерландын тамирчин Дефне Шипперс 21.88 секунд гүйж удаалсан бол АНУ-ын тамирчин 25 настай Тори Бови 22.15 секунтийн амжилтаар гуравдугаар байрт орсон байна. Элайн Томпсоны хувьд ахлах сургуульд байхаасаа гүйлтээр хичээллэж эхэлжээ. Дунд сургуульд байхдаа түүний гаргасан хамгийн том амжилт Ямайкийн Залуучуудын АШТ-д 100 метр зайг 12.01 секундэд туулсан явдал юм. Гэвч тухайн үед сахилгын шийтгэлийн улмаас гүйлтээ орхиход хүрчээ. Томпсон дунд сургуулиа төгссөний дараа Ямайкийн Технологийн их сургуульд элсэн орсон байна. Түүнийг Ямайкийн талбайн спортын хамгийн шилдэг дасгалжуулагч Стефен Францисын төрсөн ах Пол Францис олж харан, дүүдээ хэлжээ. Түүнээс хойш Томпсон Стефен Францис дасгалжуулагчтай хамт бэлтгэл сургуулилт хийх болсон байна. Тэрбээр 2013 онд Ямайкийн коллежуудын АШТ-нд хоёрдугаар байр, Төв Америк, Карибын тэнгисийн орнуудын АШТ-д алтан медаль хүртжээ. Харин 2014 онд Томпсон Коллежуудын аварга болж, Үндэсний АШТ-нд тавдугаар байранд орсон байна. Элайн Томпсон өнгөрсөн долдугаар сард Ямайкийн үндэсний аварга шалгаруулах тэмцээний үеэр 100 метрийн зайд 10.70 секундэд хурдалсан нь энэ жилийн дэлхийн рекорд болжээ.

### Өмнөд Солонгосын тамирчин олимпийн аварга боллоо

Бразилын Рио Де Жанейро хотноо болж буй зуны олимпийн XXXI дэх наадмын таеквондогийн спортын эмэгтэйчүүдийн 49 кг-ийн жингийн алтан медалийн төлөөх тулаан болж өнгөрлөө. Энэ тулаанд БНСУ-ын тамирчин Ким Со Хуй, Сербийн тамирчин Богданович Тижана нар өрсөлдсөнөөс 7:3-ын харьцаатайгаар БНСУ-ын тамирчин Ким Со Хуй өрсөлдөгчөө ялж олимпийн аварга боллоо. Ингэснээр энэ төрөлд Ази тивээс анхны эмэгтэй олимпийн аварга төрөн гарч байна. Харин Сербийн тамирчин Богданович Тижана мөнгөн медалийн эзэн болсон юм.




